



**БОЛОВСРОЛ,  
СОЁЛ,  
ШИНЖЛЭХ УХААНЫ ЯАМ**



**Дээд Боловсролын Шинэчлэлийн Төсөл**

**АХБ-ны Төслийн дугаар: 43007-023**

Төслийн код: HERP MON Зээлийн дугаар: 2766

**Дээд Боловсролын Шинэчлэлийн Олон Улсын Зөвлөх Үйлчилгээ**

**Сургалтын хөтөлбөр, сургах, сурах үйл ажиллагааны зөвлөхүүдийн  
боловсруулсан бүтээгдэхүүн**

**ДБСБ-УУДЫН ХӨТӨЛБӨР БОЛОВСРУУЛАХ, ҮНЭЛЭХ,  
ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ ЯВЦ**

**Сургалтын хөтөлбөр, сургах, сурах үйл ажиллагааны баг**

Dr. Jean-Guy Vienneau  
Олон улсын зөвлөх

Dr. А.Амарзаяа  
Үндэсний зөвлөх



**Улаанбаатар хот  
2017 он**



**PT.TRANS INTRA ASIA**

**L2766-МОНГОЛ УЛС:  
ДЭЭД БОЛОВСРОЛЫН ШИНЭЧЛЭЛ ТӨСӨЛ (ДБШТ)**

**СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨР, СУРГАХ, СУРАХ ҮЙЛ ЯВЦ**

**ДБСБ-УУДЫН ХӨТӨЛБӨР БОЛОВСРУУЛАХ, ҮНЭЛЭХ,  
ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ ЯВЦ**

## АГУУЛГА

1.	Танилцуулга.....	3
2.	Дээд боловсролын сургалтын хөтөлбөр, түүний загварууд .....	4
3.	Хөтөлбөрийн боловсруулалт, хяналт шинжилгээ .....	15
4.	Хөтөлбөрийн шилдэг туршлагууд .....	17
5.	Хөтөлбөрийн үнэлгээ, хэрэгжүүлэлт.....	22
6.	Дараагийн алхмууд, дүгнэлт.....	29

## 1. ТАНИЛЦУУЛГА

### 1.1 Танилцуулга

Орчин үеийн дээд боловсролын сургалтын байгууллага(ДБСБ)-уудад хэд хэдэн асуудал, бэрхшээл тулгараад байгаагийн дотор их сургуулиуд өнөөгийн нийгмийн хөгжил, хувьсалд хариу үзүүлэх шаардлагатай болсон. Чадварлаг мэргэшсэн багш нарын хэрэгцээ өсөн нэмэгдэж байна. Энэ чиг хандлага нь олон улсад өргөн дэлгэрч буй чиг хандлага юм.

Сүүлийн үед дээд боловсролд ялангуяа бакалаврын хөтөлбөрт тодорхой өөрчлөлтүүд бий болж, энэ нь хэд хэдэн дэвшлийг авчирсан нь дээд боловсролд шинэчлэл хийх итгэл үнэмшлийг бий болгосон. Боловсролын тэргүүлэх мэргэжилтнүүд эдгээр өөрчлөлт нь бага хүрээнд зөвхөн програмын шинэчлэл төдийхнөөр хязгаарлагдах уу эсвэл ДБСБ, дээд боловсролыг бүхэлд нь шинэчлэх үү гэдэг дээр маргаантай байр суурьтай байгаа хэдий ч, сургалтын үйл ажиллагаа, бакалаврын сургалтын хөтөлбөрүүд тодорхой хэлбэрүүдээр хувьсан хөгжсөн гэдгийг хүлээн зөвшөөрсөн байдаг.

Хичээл, програмууд нь тухайн чиглэлээр шинжлэх ухаанч, судалгаанд суурилсан сургалт олгохоос гадна нийгмийн өөр хоорондоо ялгаатай шаардлагууд, оюутны эзэмшсэн байх техникийн ур чадвар (урд өмнө ДБСБ-ууд санал болгож байгаагүй)-т нийцсэн байх шаардлагатай. Суралцагчдын хэрэгцээ, хүсэл шаардлагатай уялдуулах зорилгоор илүү уян хатан байхыг шаарддаг. Мөн оюутан хувийн зохион байгуулалтын ур чадвар эзэмшиж, насан туршийн суралцагч болж бэлтгэгдэнэ.

Илүү уян хатан, өргөн хүрээг хамарсан, ялгаатай байх (Expansion, differentiation) нь дээд боловсролын чанарын баталгаажуулалтын шинэлэг арга барилуудыг бий болгодог. Дээд боловсролын үйлчилгээнд нийгмийн болон улс төрийн дэмжлэг, оролцогч талуудын хүлээлт, дээд боловсролын хэрэгцээний нийлүүлэлтэд суурилсан хяналт, сургалтын хөтөлбөрүүд боловсруулахад тавигдах шаардлагууд, сургахуй, сурахуй үйл явцын гүйцэтгэлийн үнэлгээг багтааж өгөх хэрэгцээ одоо хэрэгжүүлж буй чанарын баталгаажуулалт, чанартай баримт бичиг, үнэлгээний шинэ хэлбэрүүдийн үр дүнд бий болдог.

Дэлхий даяар хийгдэж буй өнөөгийн судалгааны шинэчлэлүүд нь олон улсын хөгжилд, ялангуяа агуулга, судалгааны хөтөлбөрийн байгууллагуудтай холбоотой хөгжил рүү чиглэж байна. Гол онцлог нь олон талт ур чадвар буюу үндсэн чадамжуудыг оюутнуудад олгох, бүрэн эзэмшүүлэх явдал. Эдгээр ур чадвар нь оюутан мэдлэгээс гадна эзэмшсэн байх, өөр өөр ажлын байр, олон төрлийн соёл, шинэчлэн өөрчлөгдөж буй хөдөлмөрийн зах зээлд хөрвөх чадамж юм. ДБСБ-ууд ажил олгогчдын хүсэл, шаардлагыг төдийлөн анхаарч үздэггүй нь томоохон асуудал байдаг. Төгсөгчдийн ажилд орох боломжийг анхаарч үзсэнээр дээд боловсрол, дадлага ажлын хоорондын бат бэх харилцааг хангана.

Хэрэв ДБСБ-ууд орчин үетэй хөл нийлүүлж, нийгмийн хэрэгцээ, шаардлагад хариу үзүүлэхийг хүсвэл хөтөлбөр болон програмаа тогтмол сайжруулж, шинэчилж байх шаардлагатай. Дээд боловсролын оролцоо өндөр байх нь мэдлэгт суурилсан эдийн засаг руу шилжиж буй улс орнуудад чухал хүчин зүйл юм. Сургахуй, сурахуйн шинэ хэлбэрүүдтэй уялдан хөтөлбөр илүү уян хатан байх шаардлагатай болсон. Дээд боловсролын стандартуудыг баталгаажуулах, ил тод байдлыг бататгахад чанарын баталгаажуулалт чухал байр суурь эзэлдэг.

Дээрх санаанаас үзэхэд, одоо ч, ирээдүйд ч сургалтын хөтөлбөр чухал үүрэг гүйцэтгэсээр байх учир Дээд боловсролын шинэчлэл төсөл /ДБШТ/-ийн зүгээс Монголын ДБСБ-уудыг энэ систем рүү шилжүүлэхийг нэн тэргүүнд зорьж байна. Энэхүү модуль нь оролцогчдод хөтөлбөр боловсруулах, үнэлэх, хэрэгжүүлэхэд зориулсан загвар/framework/ боловсруулах боломж олгох юм.

## 2. ДЭЭД БОЛОВСРОЛЫН СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨР, ТҮҮНИЙ ЗАГВАРУУД

Хөтөлбөрийг үнэлэх, шинэ санаачлагуудыг хэрэгжүүлэхэд ДБСБ-уудын багш нар манлайлах үүрэгтэй оролцох шаардлага улам өсөн нэмэгдсээр байна. Энэхүү шаардлага нь боловсролын чанарт анхаарч эхэлсэнтэй уялдан дараах байдлаар урган гарч ирсэн. Үүнд: хүлээх үүрэг хариуцлагын талаарх мэдлэг, ойлголтыг нэмэгдүүлэх, сурлагын үр дүнг ур чадвар, үнэ цэнэ зэргийг хамааруулан өргөн хүрээнд ойлгох хандлага, салбар дундын хөтөлбөр, суралцахуй төвтэй, конструктивист сурган, хүмүүжүүлэ аргыг дэмжих хандлага өссөн зэргийг дурдаж болох юм. Мөн багш шинжлэх ухаанч арга барилыг өөрийн ажилдаа нэвтрүүлэхэд сайтар бэлтгэгдсэн байх нь чухал. Ингэхийн тулд багш нарт хөтөлбөр боловсруулах, үнэлэх, боловсруулахад боловсрол хөгжүүлэгчид, удирдах ажилтнууд, багш нарын өмнө ашигласан загвар/framework/, хуримтлуулсан туршлага хэрэгтэй.

Нийт оюутны дунд амжилтыг урамшуулах замаар хөтөлбөрөө боловсруулах нь ДБСБ-д чухал байдаг. Бүгдийг хамарсан сургалтын хөтөлбөр буюу инклюдив кюррикулум боловсруулах хандлага нь оюутнуудын боловсрол, соёл, нийгмийн суурь мэдлэг, туршлагыг авч үздэг. Энэхүү хандлага нь ДБСБ-д сургах, сурах үйл ажиллагааны тэгш байдал хангагдаж буй эсэхийг бататгахуйц хөтөлбөрийн чанарыг сайжруулах үйл явц бий болох бололцоог бүрдүүлдэг. Хөтөлбөр болон сургалтын төлөвлөгөө нь жендэрийн тэгш байдлыг анхаарч үзсэн, жэндэрийн тэгш бус байдлаас ангид байх шаардлагатай. Хөтөлбөр боловсруулагчид, мэргэшсэн үнэлгээчид агуулгын дизайн, үнэлгээний хэмжүүрээ нэгтгэх шаардлагатай. Нарийвчилсан индикаторууд /үзүүлэлтүүд/ нь хөтөлбөрийг засан сайжруулах, үнэлэх, дүгнэх үйл явцын нэг хэсэг байна.

Сургалтын хөтөлбөрийн хүрээнд хэд хэдэн чухал зарчмууд бий болсон. Дор дурдсан эдгээр зарчим нь бакалавр, төгсөлтийн дараах бүхий л түвшний хөтөлбөрт хэрэглэгдэх боломжтой. Үүнд:

1. *Философи*. Сургалтын хөтөлбөр нь боловсролын философийг сайтар авч үзсэний үндсэн дээр боловсруулагдсан, байгууллагын эрхэм зорилготой нийцсэн байна.
2. *Тодорхой зорилт/зорилгууд*. Сургалтын хөтөлбөрүүдийн эрхэм зорилго болон ойлгомжтой бичсэн зорилго(оюутны хөгжлийн ахиц буюу хүрэхээр төлөвлөсөн үр дүн) нь хөтөлбөрийн зорилтуудыг (тухайлбал, оюутнууд юу сурсан байх, юу хийж чаддаг болох, боловсролтой хүнд байх ёстой гэж багшийн итгэдэг тэдгээр хандлага, үнэ цэнэ гэх мэт)-ыг тодорхойлно. Эдгээр зорилго, зорилтыг дэлгэрэнгүй, ёс зүйтэй хэлээр илэрхийлсэн байх бөгөөд хүрэхээр төлөвлөсөн үр дүн(хөтөлбөрийн бодит үр дүн)-г үнэлэх боломжтой байна.
3. *Онолын өргөн хүрээтэй үйл явц*.Эмпэрик судалгаанд дурдсанаар, хүрэх үр дүнг тодорхойлохуйц оюутны үйл ажиллагаануудыг сонгоно. Хөтөлбөр сургалтаар дамжуулан өөрийн хүрэхээр төлөвлөсөн үр дүндээ хүрдэг. Тиймээс бүх оюутанд олгохоор төлөвлөсөн үр дүнд хүрэх явц дах бүхий л үйл ажиллагааны тодорхой үр өгөөж, чанар, хичээлийн сонголт нь аль ч хөтөлбөрийн чанарт онцгой ач холбогдолтой. Одоогийн практикт суурилсан боловсролын онол нь үр дүнтэй сургалтад чухал бөгөөд хөтөлбөрийн чанарыг сайжруулдаг. Жишээлбэл, уламжлалт лекц унших нь багшийн үнэлдэг оюутны дээд түвшний танин мэдэхүйн чадварыг хөгжүүлнэ гэсэн нотолгоо бага ч лекц унших аргыг ашигласаар байгаа төдийгүй өнөөдөр ихэнхи ДБСБ-уудын сургалтын гол арга/хэлбэр нь юм.
4. *Оновчтой шатлал*. Боловсролын үйл явц нь хөтөлбөр болон түүний бүрэлдэхүүн хичээлүүдийн аль алины хүрэхээр тодорхойлсон үр дүнд суурилсан уялдаа холбоотой хөтөлбөр боловсруулах нарийн зохион байгуулалттай хөгжлийн шатлал юм.
5. *Чанарын тасралтгүй сайжруулалт, үнэлгээ*. Оюутны хөгжил болон байгууллага, хөтөлбөрийн тодорхойлсон зорилгын бодит хэрэгжилтийг дэмжих хөтөлбөрийн үр нөлөөнд тасралтгүй хяналт шинжилгээ хийх хүчин төгөлдөр, үндэслэлтэй үнэлгээг урьдчилан төлөвлөнө. Ихэнх ДБСБ-уудад өөр хоорондоо харьцангуй ялгаатай хоёр хөтөлбөр байдаг. Нэг нь сургуулийн санал болгосон, багш нарын заавал заах ёстой хичээлүүдийн сонголт, тэдгээрийн дараалал, харин нөгөө нь оюутан бүрийн сонгон суралцах тусгай хичээл, тэдгээрийн дараалал болно. Энэхүү хоёр хөтөлбөрийн зорилго, агуулга, боловсролын туршлага нь ч өөр өөр юм. Тэнхимийн төлөвлөсөн боловсролын үйл явцад аль оюутан оролцож, аль нь хүрэхээр тодорхойлсон үр дүндээ хүрч байгааг оюутны дүнгийн жагсаалтад дүн шинжилгээ хийх замаар хяналт шинжилгээ хийж болно.

Хөтөлбөрийн загвар гаргах явцад анхаарснаар оюутан бүр чанартай сургалтын үйлчилгээ авах эрхтэй гэдэгт тулгуурлан хөтөлбөрийг илүү өргөн хүрээнд цогц байдлаар авч үзэх боломжтой юм. Мөн урьдчилан төлөвлөлтийг дэмжиж, дээд боловсролын сургах үйл явцад оролцдог бүхий л хүмүүсийг сургах, сурах үйл ажиллагаандаа оролцооны аргыг илүү идэвхитэй хэрэгжүүлэх боломжоор хангадаг. Бүхнийг хамарсан хөтөлбөр (Inclusive curriculum)-ийн загварыг тэгш байдал, хамтын ажиллагаа, уян хатан, хариуцлагатай байх гэсэн зарчмуудад үндэслэн боловсруулсан тохиолдолд багш, оюутан хоёр аль аль нь үр шим хүртдэг.

Боловсролын түвшин бүрт хөтөлбөрийг хэд хэдэн янзаар тодорхойлсон байдаг. Латтука, Старк (2009) нар дээд боловсролын хөтөлбөрийг дараах байдлаар тодорхойлжээ.

“Бакалаврын түвшинд хөтөлбөр гэдэг нь зэрэг авахаар суралцаж буй оюутнуудын сурах үйл явцад зориулсан албан ёсны сургалтын төлөвлөгөө” гэжээ. Хөтөлбөр гэдэг нь оюутны сурах зорилго (ур чадвар, мэдлэг, хандлага); агуулга (суралцсан тухайн чиглэл); дараалал (агуулгын дэс дараалал); суралцагчид; сургалтын арга, сургалтын үйл ажиллагаа; сургалтын нөөц (сургалтын материал, сургалтын орчин); үнэлгээ (эдгээр туршлагауудын үр дүн, оюутны суралцах үйл явцыг үнэлэхэд ашиглах аргууд); туршлага, үнэлгээнд тулгуурлан сургах, сурах үйл явцыг сайжруулахаар хийж буй өөрчлөлт зэргийг бүгдийг багтаасан өргөн утгатай үг юм.

Хэдийгээр хөтөлбөр гэдэг үг олон янзаар хэрэглэгддэг ч, дээрх тодорхойлолт нь бакалаврын хөтөлбөрт сурах үйл ажиллагааг сайжруулах зорилгоор хэрэгжүүлсэн сургалтын арга барил, үе шатууд, үнэлгээ, сургалтын агуулга, зорилго зэрэг олон инновацийг нэвтрүүлэхэд хангалттай хүртээмжтэй, идэвхитэй хэрэглэгдэж байв. Латтука, Старк нар хөтөлбөрийг “сургалтын төлөвлөгөө” гэсэн үзэл баримтлалын загварыг санал болгосон. Тэднийхээр, төлөвлөгөө гэдэг нь зорилго, үйл ажиллагаа, үр дүнг хэмжих арга замууд бүхий үйл ажиллагааны зураглал юм. Төлөвлөгөөний гол санаа нь суралцагчдын академик хөгжлийг дэмжих явдал. Энэ нь байгууллагын зорилго, багш, оюутан, суралцах чиглэлээс хамааран өөр өөр байх боловсролын чухал асуудлуудад төвлөрлөдөг төлөвлөлтийн үйл явц юм.

Төлөвлөгөө буюу үзэл баримтлалын загвар нь суралцагчдын боловсролын үйл явцтай холбоотой бүхий л зорилгод хүрэхэд дараах чухал элементүүдийг агуулдаг. Хөтөлбөрийг боловсруулахдаа эдгээр элемент, хүчин зүйлүүдийг анхаарч үзсэн байх шаардлагатай. Доорх хүснэгтэд тэдгээр элементүүдийг тодорхойлолтын хамт харуулав:

<b>ЭЛЕМЕНТҮҮД</b>	<b>ТОДОРХОЙЛОЛТ</b>
Зорилго	Мэдлэг, ур чадвар, хандлага бий болно.
Агуулга	Тодорхой мэдлэг, ур чадвар, хандлагыг олгохоор сонгосон чиглэл
Шатлал/дараалал	Суралцагчдыг тодорхой үр дүн рүү чиглүүлэх чиглэл, туршлагын зохицуулалт
Суралцагчид	Бүлэг суралцагчдын онцлогийг төлөвлөгөөнд хэрхэн тусгасан
Сургалтын үйл явц	Суралцах үйл явцад хэрэглэгдэх материал, сургалтын орчин
Үнэлгээ	Сургалтын төлөвлөгөөний элементүүдийн тухай шийдвэр оновчтой эсэхийг тодорхойлоход ашиглах аргууд
Өөрчлөлт	Туршлага, үнэлгээнд тулгуурлан төлөвлөгөөг сайжруулах үйл явц

## Хүснэгт 2. Сургалтын төлөвлөгөөний элементүүд (Lattuca and Stark, 2009)

ДБСБ-уудын өмнө тавигдаж буй бусад анхаарах асуудлууд нь боловсролын агуулгын нийцэл, боловсролын туршлагыг сайжруулах зорилгоор хийгдэж буй хөтөлбөрийн инноваци, шинэчлэлүүд юм. Сүүлийн 30 жилийн хугацаанд хөтөлбөрт хийгдсэн олон шинэчлэл, өөрчлөлтөөс гурван гол өөрчлөлтийг онцолбол:

1. Агуулгыг бүрэн эзэмшүүлэхэд голлон анхаардаг сургалтын зорилгоос чадамжийг өргөн хүрээнд эзэмшүүлэх зорилгод шилжсэн,

2. Суралцахуйн салангид хэлбэрээс хөтөлбөр хооронд шилжин сурах интеграцчилсан хэлбэрт шилжсэн,

3. Хичээлийн сэдэв нь гол гэж үздэг хэлбэрээс хөтөлбөрийн шинэчлэлийн чухал хэсэг болох сургалтын арга, үнэлгээний шинэ арга хэлбэр, санаачлагуудад шилжсэн.

Мөн төгсөгчид өөр өөр үндэстний хүмүүстэй харилцах, олон улсад өрсөлдөх чадвар эзэмшсэн байх нь бакалаврын хөтөлбөрийн гол анхаарах асуудал болсон.

**Агуулгаас чадамж руу.** XXI дүгээр зууны эхний жилүүдэд, бакалаврын хөтөлбөр нь ерөнхий боловсрол буюу ерөнхий эрдмийн (либерал арт), мэргэжлийн, хавсарга, сонгон суралцах хичээлүүдээс бүрддэг байдал үргэлжилсээр байв. Энэ хэлбэрийн суурь нь үндсэн мэргэжлийн мэдлэг, шаардлагыг олгох замаар агуулгыг бататгах явдал байсан бол агуулгаас чадамжид шилжсэнээр сурах зорилго нь мэргэжлийн хичээлийн агуулга, үзэл баримтлалын талаарх мэдлэг (оюутан юу мэдсэн байх) олгохоос XXI зууны иргэн эзэмшсэн байх шаардлагатай чадамж(оюутнууд юу мэдсэн байх, юу хийж чаддаг байх)-ийг эзэмшүүлэх болж өөрчлөгдсөн.

Ихэнхдээ ДБСБ-ууд өөрсдөө тодорхойлсноор төгсөгчдийн эзэмшсэн байх чадамжийн жагсаалт дараах байдлаар нэмэгдсээр байна. Үүнд:

- Эргэцүүлэн бодох болон асуудал шийдвэрлэх чадвар,
- Байгалийн ухаан, математик, нийгмийн шинжлэх ухаан, хүмүүнлэг, урлагын салбарын өөр өөр эрэлт хэрэгцээнд хөрвөх чадвар,
- Бичих, ярих, сонсох чадваруудыг багтаасан харилцааны чадвар,
- Мэдээлэл, технологийн мэдлэг,
- Өөр өөр чиг хандлагад мэдрэмжтэй байх, тухайлбал жэндэрийн асуудал, олон ургальч ардчилсан нийгэмд оролцоходоо олон соёл болон олон улсад өрсөлдөх чадвар,
- Иргэний, олон улсын, байгаль орчны үүрэг хариуцлага, оролцоо,
- Багаар ажиллах, бусадтай хамтран ажиллах зэрэг хувийн чадварууд,
- Зан байдал, ёс суртахууны төлөвшил,
- Өөр өөр эх сурвалжаас мэдлэг олж авах чадвар зэргүүд болно.

**Хөтөлбөрийн интеграцлал.** Ихэнхи ДБСБ-уудын удирдлага, багш нарын дунд ерөнхий боловсрол тэргүүлэх байр суурь эзэлдэг, тиймээс байгууллага ерөнхий боловсролын хөтөлбөрүүдийг хянах үйл явцад илүү идэвхитэй оролцдог гэдгээ баталсан байдаг. Ерөнхий эрдмийн хичээлийн хөтөлбөрийн хүрээнд өмнө дурдсан бүх чадамжийг эзэмших нь хүндрэлтэй, учир нь ихэнхи ДБСБ-ууд боловсрол олгох бүхий л явцад эдгээр чадамжийг тусгахдаа ерөнхий эрдмийн хичээл, үндсэн мэргэжлийн хичээлийн хоорондын зааг ялгааг нарийн гаргадаггүй. Хөтөлбөрийн интеграцлал гэдгийг багаар, төсөл хөтөлбөрийн хүрээнд хамтран ажиллахыг шаардах капстоун хичээлүүд; ёс суртахуун, иргэний оролцоог чухалчилдаг мэргэжлийн хичээлүүд, хөтөлбөрийн хүрээнд олон талт соёл, мэдээллийн боловсрол, технологийг интеграцчлах гэж үзэж болно.

**Өөр өөр онцлогийг харгалзан үзсэн сургалт:** Хэдийгээр олон янзаар тодорхойлогддог ч, энэ нь өөр өөр чиг хандлагад мэдрэмжтэй байх (арьс өнгө, жендэр, нийгэм-эдийн засгийн ялгаа,

үндэстэн ястан, шашин, бэлгийн чиг хандлага, хөгжлийн бэрхшээл гэх мэт) гэсэн үг юм. Мөн хүмүүнлэг, нийгмийн ухааны хөтөлбөрүүдэд энэхүү өсөн нэмэгдэж буй соёлын олон талт үзэл тусгагдаж эхэлсэн.

**Олон улсын шинжтэй болох.** Олон улсад өрсөлдөх чадамжийг либерал арт сургалтын эрхэм зорилго гэж тодорхойлдог, гэвч одоогоор маш цөөхөн оюутан их сургуульд суралцах хугацаандаа олон үндэстний хүмүүстэй харилцах чадвараа хөгжүүлж байна. Олон улсын шинжтэй болоход гадаад хэлний сургалт, гадаад дах сургалт, олон улсын судлал, гадаад оюутнуудтай байх гэсэн нийтлэг 4 элемент салшгүй холбоотой.

Үүнтэй зэрэгцэн, “багш нар юу заах вэ” гэдгээс “оюутнууд юу сурах вэ” гэдэг хандлагад шилжсэнээр судалгаанд гайхалтай ахиц дэвшлүүд бий болсон. Сургалтын шинэ үзэл баримтлалууд мэдлэгт суурилсан нийгмийг бүтээхэд анхаарч байна. Эмэгтэйчүүд судлал, ёс зүйн судлал зэрэг шинэ салбар дундын мэргэжлүүд нэмэгдэж байна. Багшийн үүрэг хариуцлага, урамшууллын тогтолцоог дахин нарийвчлан авч үзэх нь чухал бөгөөд ингэснээр сургалтын үйл явц, багшийг урамшуулахад шударга байдлыг бий болгоно. Багшийн хөгжил нь багш нарт сургалтын үйл ажиллагаагаагаар сайжруулахад нь туслах практик үйл ажиллагаа болон хөгжиж байна. Энэ хугацаанд олон тооны ДБСБ “Сургахуй, Суралцахуй төв”-үүдийг байгуулсан байдаг. Мөн, сургалтын шинэ чиглэлүүд, тэдгээрийг сургалт, судалгаанд ашиглахад зориулсан шинэ технологит давуу талууд ч бас бий болов. Эдгээр хүчин зүйлүүдийг хамтад нь авч үзсэнээр дээд боловсролыг хөгжүүлэх чухал шинэчлэлүүдийг бий болгосон.

Түүнчлэн, өнөөгийн ДБСБ-ууд суралцагчдыг олон улсад өрсөлдөхүйц, хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, хэрэгцээнд нийцүүлэн бэлтгэх шаардлагатай болсон. Суралцагчийг их сургуулиас хөдөлмөрийн ертөнцөд шилжих явцыг хялбаршуулах үүднээс ДБСБ-ууд семинар, дадлага ажлыг санал болгож байна. Эдгээр семинар, дадлага ажлууд нь оюутан үндсэн мэргэжлийн хүрээнд сурсан, мэдсэнээ олон нийтийн буюу хөдөлмөрийн зах зээлийн хэрэгцээнд нийцүүлэн ашиглахад туслах зорилгоор боловсруулагдсан.

**Суралцагчдын бүлэг.** Энэ нь сургалтын хөтөлбөрүүдийн хамаарлыг бэхжүүлэх, оюутнууд өөр хоорондоо болон багш нартай хамтран ажиллах боломжуудыг нэмэгдүүлэх, бие биедээ туслах/дэмжих, хичээл болон дасгал ажлаар оюутнуудыг холбодог хөтөлбөрийн загварууд. Хэдийгээр нэгдүгээр курсын оюутнуудад зориулан боловсруулдаг байсан ч одоо хөтөлбөрийн бүхий л түвшинд бий болсон. Энэ загварыг суралцагчдын бүлэг байгуулахаар боловсруулдаг ч ихэнх тохиолдолд хамтарсан, салбар дундын хичээл/хөтөлбөрийн бүтцийг дэмжихэд чиглэсэн байдаг.

**Салбар дундын хамтарсан хөтөлбөрийг** сургалт, судалгааны гол чиг хандлага гэж үздэг бөгөөд энэ төрлийн хөтөлбөр эрчимтэй хөгжиж байна. Онцлог нь сэдэв болон асуудалд суурилсан салбар дундын семинар, хичээлүүд байх ба эдгээрийн ихэнх нь багаар хичээллэдэг. Мөн багш заах арга зүй, хичээлийн зохион байгуулалтын шинэлэг хэлбэрийг ашиглан салбар хооронд хичээл заадаг. Энэ нь хамтарсан болон салбар дундын хөтөлбөрийн талаарх ойлголт (олон төрлийн сэдэв хамарсан группын ажил, дадлага ажлууд, судалгаа, гадаад суралцах гэх мэт)-ыг нэмэгдүүлдэг.

**Чадамжийн жагсаалт.** Ихэнхдээ ДБСБ-ууд өөрсдөө тодорхойлсноор төгсөгчдийн эзэмшсэн байх чадамжийн жагсаалт дараах байдлаар нэмэгдсээр байна. Үүнд:

- Эргэцүүлэн бодох болон асуудал шийдвэрлэх чадвар,
- Байгалийн ухаан, математик, нийгмийн шинжлэх ухаан, хүмүүнлэг, урлагын салбар дахь өөр өөр эрэлт хэрэгцээнд хөрвөх чадвар
- Бичих, ярих, сонсох чадваруудыг багтаасан харилцааны чадвар,
- Мэдээлэл, технологийн мэдлэг,
- Өөр өөр чиг хандлагад мэдрэмжтэй байх, тухайлбал жэндэрийн асуудал, олон ургальч ардчилсан нийгэмд оролцоходоо өөр өөр соёл, олон улсад өрсөлдөх чадвар,
- Иргэний, олон улсын, байгаль орчны үүрэг хариуцлага, оролцоо,
- Багаар ажиллах, бусадтай хамтран ажиллах зэрэг хувийн чадварууд,



- Зан байдал, ёс суртахууны төлөвшил,
- Өөр өөр эх сурвалжаас мэдлэг олж авах чадвар зэргүүд болно.

Петер Вольф Канадын Queen's их сургуулийн багш бөгөөд дээд боловсролын хөтөлбөрийн талаар мэргэшсэн хүмүүсийн нэг юм. Түүний гол санаа нь хичээл болон хөтөлбөрийн оролцоогоор дамжуулан боловсролын хөгжлийг илүү өргөн хүрээнд авч үзэх асуудал байв. Тэрээр Saskatchewan их сургуульд байхдаа “Хөтөлбөр, Инноваци, Шинэчлэлийн үе шат” загвар боловсруулахад голлох үүрэгтэй оролцсон. Уг загварт 6 үндсэн алхам шаардагдах ба инноваци, шинэчлэлийг дэмжиж байдаг 4 тулгуур ойлголт байдаг байна.

“Хөтөлбөр, Инноваци, Шинэчлэлийн үе шат”- Саскачеван их сургуулийн загвар

Загварын 6 үндсэн алхмыг дор дурдав. Үүнд:

1. Мэдээлэлд тулгуурласан төсөөлөхүй буюу алсын хараа: Ирээдүйг анхаарч үзсэн, алсын хараанд чиглэсэн хөтөлбөрийн үе шатуудыг тодорхойлох. Ингэхдээ хөтөлбөрөө судалсны дараа оюутнууд ямар мэдлэг, чадвар эзэмшсэн байх вэ?, маргаашийн нийгэм, ажил олгогчид ямар шаардлага тавих вэ? гэдэг асуултуудад төвлөрнө.
2. Нөөц: Энэ үе шатад хөтөлбөрийнхөө одоогийн нөхцөл байдал, одоо юу санал болгож байгаагаа болон хөтөлбөрийн бодит агуулгын дүн шинжилгээнд анхаарна.
3. Уялдаа холбоо(нийцэл)-г тодорхойлох: Ингэхдээ өмнөх шатанд юу хийсэн болон хүрэхээр тодорхойлсон алсын хараанд дүн шинжилгээ хийж, аль алиныг нь харьцуулах замаар байж болох ижил ба ялгаатай талуудыг тодорхойлно.
4. Хэрэгжүүлэх: Энэ үе шатад хөтөлбөрт хийх шаардлагатай өөрчлөлтүүдийг олж тодорхойлон, тэдгээр санал болгож буй өөрчлөлтийг хэрэгжүүлэх арга зам, үйл ажиллагааг боловсруулна.
5. Үр нөлөөг нягтлах: Санал болгосон өөрчлөлтүүд, тэдгээрийг хэрэгжүүлэх явцад бий болсон бодит үр дүн ирээдүйд ямар үр нөлөө үзүүлэх талаар үнэлгээ хийнэ.
6. Дахин төсөөлөх: Зохиогчийн танилцуулсан энэхүү эцсийн үе шатад дараагийн алхмуудыг авч үзэн, өнөөгийн болон ирээдүйн хэрэгцээг тусган шинэчилсэн хөтөлбөр, хичээлүүд боловсруулахын ач холбогдлыг дахин бататгана.

Дээр дурдсанчлан, Вольфийн танилцуулсан загварыг дэмжих 4 тулгуур ойлголт байдаг. Саскачеван их сургуулийн хувьд i) мэдлэг бүтээх, ii) Уугуул иргэд/олон нийтийн оролцоо (Aboriginal participation/communities), iii) шинэ санаачлага-инноваци, iv) соёл, олон нийт гэсэн анхаарч үзэх 4 гол чиглэл байв.

1. Мэдлэг бүтээх гэдэг нь
  - Шинэлэг практикууд,
  - Шилдэг багш/судлаачийг авч ажиллуулах,
  - Багш, оюутныг амжилт гаргахад туслах,
  - Стратегийн зорилтыг бэхжүүлэх.
2. Уугуул иргэдийн оролцоо гэдэг нь:
  - Сургуулийн байранд уугуул иргэдийн соёл, бэлгэ тэмдгийн харагдах байдлыг нэмэгдүүлдэг,
  - Орон нутгийн олон нийттэй тогтвортой харилцааг бэхжүүлдэг,
  - Амжилтаа тэмдэглэдэг.
3. Академик програмын болон үйлчилгээний шинэ санаачлага гэдэг нь:
  - Суралцагч төвтэй програмчлал, хөтөлбөрийн шинэ санаачлагад анхаардаг,
  - Оюутны бүтээлч байдал, шинэ санаачлагыг дэмждэг,
  - Бүх туршлага, арга барилын үр өгөөжийг харуулдаг,
  - Бүх оюутанд зориулан сургалтын үр дүнг тодорхойлдог.
4. Соёл, олон нийт гэдэг нь:
  - Өөрчлөлт, эрсдэлд бэлэн, нээлттэй байдаг,
  - Шинэ оролдлого, шинэлэг үйл ажиллагааг дэмждэг,
  - Хөтөлбөр бүх хүнд чиглэсэн, өөр өөр үндэстэнд тохирсон байхыг дэмждэг,

Энэ загварт 2008 онд Америкийн коллеж, их сургуулиудын холбооны боловсруулсан “Өндөр үр нөлөөтэй боловсролын 10 туршлага” (High-Impact Educational Practises)-ыг нэмж оруулсан. Эдгээр туршлагууд нь оюутан амжилт үзүүлэхэд нөлөөлөх чухал хүчин зүйлүүд бөгөөд загваруудыг өргөн хүрээнд туршиж, их сургуулийн өөр өөр мэдлэг, боловсролтой оюутнуудад үр өгөөжтэй болохыг баталсан байдаг. Эдгээр нь ДБСБ-ын нөхцөл байдал, тэргүүлэх чиглэл, суралцагчдын онцлог зэргээс хамаараад өөр өөр хэлбэртэй байж болох юм. Тэдгээр 10 туршлагыг дурдвал:

#### 1. Нэгдүгээр курсийн семинар, дадлага ажил

Өнөөдөр ихэнх ДБСБ-ууд нэгдүгээр курсийн семинар, бусад програм (оюутнууд жижиг групп хуваагдан, багш эсвэл холбогдох мэргэжилтний удирдлагад тогтмол хичээллэдэг)-уудыг хөтөлбөрт тусгаж өгдөг болсон. Энэ төрлийн хамгийн чанартай сургалтууд нь дүн шинжилгээ хийх, мэдээлэл боловсруулах, хамтран суралцах гэх мэт оюутнуудын оюуны болон практик чадваруудыг хөгжүүлэх чадваруудад голлон анхаардаг. Мөн өнөөг хүртэл маргаантай байгаа асуултууд болон багш өөрийн судалгаан дээр оюутнуудыг ажиллуулах замаар тэдний оролцоог нэмэгдүүлдэг.

#### 2. Оюуны нийтлэг дадлага, туршлагууд

Цөм хөтөлбөрийн хуучин санаа нь орчин үеийн хэлбэрүүдийн олон төрөлд тухайлбал, заавал үзэх ерөнхий хичээлүүдийн багц, эсвэл босоо бүтэцтэй ерөнхий боловсролын програмд шилжжээ. Эдгээр програм нь оюутнуудад зориулсан олон төрлийн хөтөлбөр, хамтарсан хөтөлбөрийн сонголт бүхий технологи, нийгэм, дэлхийн харилцан хамаарал гэх мэт өргөн сэдвүүдийг хамардаг.

#### 3. Суралцагчдын бүлэг

Гол зорилго нь хичээл хоорондын сургалтын интеграцчлалыг дэмжих, оюутнуудыг хичээлээс гадуурх “том асуултууд”-аар дамжуулан татан оролцуулах явдал юм. Оюутнууд групп болон хуваагдаж хоёр ба түүнээс дээш хоорондоо холбоотой хичээлийг сонгон өөр хоорондоо болон багш нартайгаа нягт хамтран ажилладаг. Эдгээр бүлэг өөр өөр мэргэжлийн чиглэлийг хамарсан нийтлэг сэдэв/ нийтлэг уншлага хийх замаар эрэл хайгуул хийдэг. Зорилгоосоо хамааран “ерөнхий эрдэм”-ийн, мэргэжлийн болон бусад сургалтуудтай холбогддог.

#### 4. Бичих ур чадвар –Эрчимжүүлсэн курсууд

Эдгээр хичээлийг сургалтын бүх түвшний хөтөлбөрт багтаадаг. Оюутнуудыг төрөл бүрийн салбарын өөр өөр хүмүүст зориулан олон төрлийн бичвэр /writing/ бичих, түүнийгээ засан сайжруулахыг хөхүүлэн дэмждэг. Хөтөлбөрийн хүрээнд тогтмол давтдаг энэхүү дадлага ажлын үр нөлөөгөөр оюутны ярих, тоон мэдээлэл дээр ажиллах, мэдээлэлд дүн шинжилгээ хийх чадвар мөн ижил хэмжээгээр хөгждөг байна.

#### 5. Хамтарсан төсөл, даалгавар

Хамтран суралцах нь 1) бусадтай хамтран ажиллаж, асуудлыг хамтран шийдвэрлэхэд суралцах, 2) бусдын ялангуяа, өөр өөр боловсрол, амьдралын туршлагатай хүмүүсийн үзэл бодлыг бүрэн сонсох замаар өөрийн ойлголтыг бэхжүүлэх гэсэн хоёр үндсэн зорилготой. Хичээлийн хүрээнд хэд хэдэн судалгааны багт хуваах, багаар хийж гүйцэтгэх даалгавар, эссэ, төсөл, судалгааг хамтран хийх зэрэг аргуудыг ашиглана.

#### 6. Бакалаврын түвшний судалгаа

Өнөөдөр олон коллеж, их сургуулиуд судалгааны ажил хийх боломжийг бүхий л мэргэжлээр суралцаж буй оюутнуудад олгож байна. Бакалаврын түвшний судалгаа, хэдийгээр шинжлэх ухааны чиглэлд илүү чухал хэрэглэгддэг байсан ч судалгааны багийн тууштай дэмжлэгээр оюутнуудыг системтэй судалгаа, шинжилгээнд аль болох эрт, идэвхитэй хамруулах зорилгоор багш нар хичээлүүдээ гол агуулга, асуултуудтай холбон шинэчлэн боловсруулж байна. Гол зорилго нь өнөөг хүртэл маргаантай байсаар байгаа асуултуудын хүрээнд мэтгэлцүүлэх, эмпэрик туршилт хийх,

хамгийн сүүлийн үеийн технологи ашиглах, мөн “чухал асуулт”-ад хариу өгөхөөр ажиллах үед бий болдог сэтгэл хөдлөлийг хөшүүрэг болгон оюутнуудын оролцоог нэмэгдүүлэх явдал юм.

#### 7. Ялгаатай байдал/ Глобаль суралцахуй

Өнөөдөр олон их сургууль оюутнуудад соёл хоорондын ялгаа, амьдралын туршлага, ертөнцийг өөр өөрийн зүгээс танин мэдэхэд нь туслах хичээл, програмд анхаарлаа хандуулах болсон. Эдгээр хичээл, програм нь дэлхийн олон соёл, өөр өөр үндэстний онцлогийг судалдаг.

#### 8. Үйлчилгээний ажлаар дамжуулан суралцах, Нийгэмд суурилсан суралцах үйл ажиллагаа

Эдгээр програмын хүрээнд, сургалтын гол арга барил нь олон нийтийн түншүүдтэй хамтран ажлын талбарт суурилсан практик сурах үйл явц байдаг бөгөөд тухайн хичээлийн салшгүй нэг хэсэг байдаг. Гол зорилго нь оюутнууд өөрсдийн суралцаж буй хөтөлбөрийн хүрээнд тулгарч буй асуудлуудтай бодит байдал дээр танилцах, туршлага хуримтлуулах, нийгэм дэх асуудлыг шийдвэрлэх, дүн шинжилгээ хийхээр хүчин чармайлт гаргах боломжуудыг олгоход чиглэнэ. Эдгээр програмын чухал элемент нь оюутнууд юу сурснаа бодит амьдралын нөхцөлд хэрэглэх, эргээд практикаас хуримтлуулсан туршлагаа танхимын сургалтад тусгах боломжоор хангадаг. Энэ төрлийн програмуудын загвар нь “олон нийтэд ямар нэгэн зүйл буцааж өгөх” нь сургуулийн чухал үр дүн төдийгүй олон нийтийн түншүүдтэй хамтран ажиллах нь оюутныг иргэншил, ажил, амьдралд сайтар бэлтгэх гэсэн санаа юм.

#### 9. Дадлага ажил

Сургалтын туршлагаар бий болсон хөгжиж буй өөр нэг нийтлэг хэлбэр нь дадлага ажил. Гол санаа нь оюутнуудын мэргэжлийн сонирхлын дагуу тэднийг ажлын бодит нөхцөлд дадлагажуулах, тухайн салбарын мэргэжилтнүүдийн удирдлага, чиглэлээс суралцах боломжийг олгох зорилготой. Хэрэв дадлагын ажлаар багц цаг/кредит тооцдог бол оюутнууд төсөл эсвэл судалгаа хийж гүйцэтгэн удирдагч багшаар баталгаажуулж болох юм.

#### 10. Төгсөлтийн болон төсөлт ажил

Юу гэж нэрлэхээс үл хамааран, энэхүү туршлага, дадлагууд нь их сургуулийн төгсөх курсын оюутнуудыг сурсан, мэдсэнээ ашиглан, нэгтгэх замаар нэгэн төрлийн төсөл хийхийг шаарддаг. Төсөл нь судалгааны ажил, үзүүлэн тоглолт, “шилдэг ажлууд”-ын цуглуулга, бүтээлийн үзэсгэлэн аль нь ч байж болно. Төгсөлтийн ажлуудыг тэнхмийн болон ерөнхий боловсролын програмуудад санал болгох нь нэмэгдсээр байна.

Танилцуулж буй энэ загвар нь 5 хэмжигдэхүүнээс бүрддэг бөгөөд тэдгээр нь суралцагчийн боловсролын амжилтад чухал нөлөөтэй.

- Нээлт: Шинэ мэдээлэл сурах, шинэ туршлага эрж хайх хүсэл эрмэлзэл бий болгоно,
- Мэдлэг: Оюутнуудад зааж буй болон тэдний сурч буй хөтөлбөрийн агуулга
- Шударга байх: Шударга, найдвартай байдал нь ДБСБ-уудын үндсэн чиглүүлэх зарчмууд байна.
- Ур чадвар: Их сургуульд суралцах бүхий л хугацаанд оюутнуудын эзэмших чадварууд
- Иргэний эрх үүрэг: Нийгмийн хариуцлагыг ДБСБ-уудын оюутнуудын сурах үйл явцад оруулсан байна.

#### Багш нарт өгөх зөвлөгөө

Багш нар ихэнх тохиолдолд орхигдуулдаг байсан хөтөлбөрийн асуудлуудад эргээд анхаарал хандуулах замаар үр дүнтэй хөтөлбөрийн өрсөлдөөнд хариу үзүүлэх шаардлагатай тулгарч байна. Үр дүнтэй хөтөлбөр сургуулийн бүх (дотоод, гадаад) оюутны хүсч буй үр дүнг бий болгодог, зөвлөн туслах үр өгөөжтэй програмын амжилтыг дэмждэг. Орчин үеийн зөвлөн туслах үйлчилгээ нь оюутан

бүрийн итгэл үнэмшил, зорилгоос эхлээд тэдний хувийн болон их сургуулийн төлөвлөсөн сургалтын үр дүнд хүрэх сурах үйл явцаа боловсруулахад нь тусалдаг.

Хөтөлбөрийн хүрэх үр дүнг сайн, ойлгомжтой тодорхойлсноор багш хөтөлбөрийг ойлгох, хөтөлбөрийн хүрээнд зөв харилцаа үүсгэх, хөтөлбөрийг хянах, үр дүнтэй удирдах боломжтой болно. Тиймээс ойлгомжтой, сайн тодорхойлсон үр дүнгүүд өнөөдрийн хөтөлбөр боловсруулах, хэрэгжүүлэх, үнэлэх үйл явцад маш чухал. Хөтөлбөрийн үр дүнгийн зорилго, зорилтууд нь:

1. Хүрэхээр зорьж буй үр дүнгийн бодит үндэслэлийг хангадаг,
2. Хөтөлбөрөөс гарч буй бодит үр дүнд тогтмол хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхэд тодорхой чиглэлээр хангадаг,
3. Оновчгүй сургалтын үйл ажиллагааг туршин хэрэгжүүлэх байдлыг багасгадаг, Сургалтын үйл ажиллагаа болон үнэлгээний шалгуур үзүүлэлтүүд аль аль нь багш нарын өмнө тодорхойлсон үр дүнд чиглэсэн байдаг.
4. Хөтөлбөрийг өөр өөр улс үндэстний оюутнуудад нийцүүлэхгүй орхих, хөтөлбөрийн бэлтгэлийг дутуу хангахаас сэргийлж, оюутнуудын хувиран өөрчлөгдөж буй эрэлт хэрэгцээнд нийцүүлэн боловсролын үйл явцыг өөрчлөх, үр дүнгийн стандартуудыг маш нарийн тодорхойлох шаардлагатай.
5. Дүнгийн инфляц(grade inflation)-иас үүдэн оюутны болон багшийн тоо багасах, сургалтын чанарт сөргөөр нөлөөлөх, боловсролын зэргийн үнэ цэнэ буурахаас сэргийлдэг,
6. Байгууллага, хөтөлбөр зөвхөн нэг эрхэм зорилго эсвэл зорилтод хэт төвлөрснөөр бусад зорилго, зорилтууд орхигдож байгааг шүүмжлэх, холбогдох шаардлага тавих боломжоор багшийг хангадаг,
7. Хөтөлбөрийн агуулгын талаарх аливаа маргаанд илүү шударга, үндэслэлтэй хандах боломжийг багшид олгодог, жишээлбэл, тэнхим, бүрэлдэхүүн сургуулийн асуудалтай холбоотой маргаан гэх мэт.
8. Багш нар, оюутнууд, удирдах ажилтнууд, итгэмжлэгчид, эцэг эх зэрэг хөтөлбөрт оролцогч бүх хүмүүст сургууль, програмаас хүлээгдэж буй үр дүнг ойлгоход нь тусалдаг,
9. Сургуулийн ил тод, нээлттэй, шударга байдлын талаарх ойлголтыг байгууллагын бүхий л оролцогч талууд, харилцагчдын дунд нэмэгдүүлдэг.

Хилда Таба өөр нэг оновчтой загварыг боловсруулсан нь нэмэлт алхмуудыг оруулсан, алхам бүрт илүү дэлгэрэнгүй мэдээлэл шаардагддаг хөтөлбөр боловсруулах үйл явцад үндэслэсэн загвар байв. Тэдгээр нэмэлт алхмууд нь:

- Алхам 1: Хэрэгцээг тодорхойлох
- Алхам 2: Зорилтоо тодорхойлох
- Алхам 3: Агуулгын сонголт
- Алхам 4: Агуулгын зохион байгуулалт
- Алхам 5: Суралцах үйл явцын сонголт
- Алхам 6: Суралцах үйл явцын зохион байгуулалт
- Алхам 7: Юуг, ямар арга замаар, ямар хэмжигдэхүүнээр үнэлэх вэ гэдгийг тодорхойлох зэрэг болно.

Хөтөлбөр нь дээд боловсролын суралцагч, курсын ажлын хоорондын тэнцвэртэй харилцаа юм. Энэ нь сургуулиас эсвэл хичээлээс хуримтлуулсан оюутнуудын туршлага байна. Силабус (syllabus) бүр оюутнууд үнэхээр их сургуульд суралцдаг гэдгийг нотлох баримтын нэг хэсэг болно. Хөтөлбөр баримтлах загвар, хэрэглээ, практик, элсэлт зэргээс хамааран боловсролын түүхэнд урьд өмнө байснаас илүүтэй өөр хоорондоо (суралцагчидтай адил) ялгаатай болсон.

Латин хэлэнд үндсэн утга нь хурд, чиглэл гэсэн аль аль утгаар хэрэглэгдэж байсан шиг хөтөлбөр гэдэг нь яг л тогтсон чиглэлд, чөлөөтэй урсдаг голтой адилхан юм.

Ирээдүйд, хүмүүс үр бүтээлтэй ажиллах хугацааныхаа туршид ажил мэргэжлээ хэд хэдэн удаа солих хандлагатай байна. Нийгэм дэх ажил эрхлэлтийн өөрчлөлтийн мөн чанараас хамааран

боловсролын зорилго ч мөн өөрчлөгдөнө. Шилжилтийн явцад оюутны болон сургалтын үр дүнг хэмжихэд хөтөлбөр маш чухал хэмжүүрийн үүрэг гүйцэтгэнэ. Тиймээс, аль ч ДБСБ-ын хөтөлбөрийн үнэлгээ нь нийгмийн эрэлт хэрэгцээ, холбогдох асуултууд, дээд боловсролыг санхүүжүүлдэг төрийн байгууллагууд, бие даан суралцагчид болон оролцогч талуудад хамгийн оновчтой хариултуудыг өгдөг байх шаардлагатай.

Бакалаврын хөтөлбөрийг тархай бутархай, уялдаа холбоогүй, хэт олон салангад мэдээлэлтэй учраас төвөгтэй гэсэн шүүмжлэлд хариулахын тулд ДБСБ-ууд оюутнуудын коллежийн туршлагад тус тусдаа байсан элементүүдийг нэгтгэхэд туслах стратеги, үйл явцыг боловсруулсан. Нэгдүгээр стратеги нь хөтөлбөрт тавигдах шаардлагыг тодорхой болгох, чангатгах, дэс дараалалд оруулах, ингэснээр илүү их уялдаа, холбоог бий болгоно. Хоёрдугаар стратеги нь их сургуульд суралцах хугацааны өөр өөр үе шатанд оюутнуудын хөгжлийн хэрэгцээнд тохирсон боловсролын үйл явцаар хангана.

Жендерийн ур чадвар эзэмших нь хүний нөөцийн хөгжил, бага тушаалын ажилтнуудыг дэвшүүлэх, хүйсийн онцлогийг харгалзан боловсруулсан заах арга зүй зэрэгт зайлшгүй шаардлагатай болох нь тодорхой болсон. Жендерийн онцлогийг харгалзан үзсэн загвар залуу эмэгтэй, эрэгтэй хүмүүсийн амьдралын нөхцөл байдал, хэрэгцээний онцлог, үзэл бодлын өнцгөөс санал болгосон хичээлийн програмын загвар, хөтөлбөрийн бүтэц, сургах, сурах үйл ажиллагааны хэлбэрүүд, заах арга зүй дэх жендер, эмэгтэйчүүдийн интеграцийг авч үзэхтэй холбогдоно.

Үндсэндээ, хөтөлбөр боловсруулах хоёр өөр арга байдаг. Нэг нь мэргэжилд төвлөрсөн, нөгөө нь сурахад төвлөрсөн. Та бүгдийн ойлгосноор бид хоёрдах буюу сурахад төвлөрсөн аргыг илүү ач холбогдолтой гэж үзэж байгаа.

Мэргэжилд төвлөрсөн арга болон түүний онцлог шинжүүдийг авч үзвэл:

<b>ХЭМЖИГДЭХҮҮН</b>	<b>ШИНЖ ЧАНАР</b>
Мэргэжилд суурилсан	Мэргэжлийн тогтсон бүтцэд төвлөрч, мэргэжлийн хүрээнд ажиллахыг хүмүүсээс шаарддаг. /мэргэжлийн чиглэлүүдийн дунд байх мэдлэгийг үл ойшооно/
Өргөн салбар /broad fields/	Шинжлэх ухаан, хүмүүнлэг, нийгэм судлал зэрэг хэд хэдэн салбарыг нэгтгэдэг. /интеграцийг илүү их зөвшөөрдөг/.
Агуулгын кластер /cluster/	Шинжлэх ухаан, технологи, нийгэм гэх мэт хэд хэдэн кластертай байж болно.
Сэдэвт суурилсан	Агуулгуудын хоорондын холбоо/хэв маягийг олохыг чухалчилдаг. Соёл, туршлагад үндэслэдэг.

Хүснэгт 4. Хөтөлбөр боловсруулах мэргэжилд төвлөрсөн арга

Суралцагч төвтэй арга ба түүний онцлогууд:

<b>ХЭМЖИГДЭХҮҮН</b>	<b>ШИНЖ ЧАНАР</b>
Харилцан зөвшилцсөн	Боломжтой байгаа нөөц бололцооны хүрээнд, суралцагчид юуг сурах, юу сурах шаардлагатай байгаагаа харилцан зөвшилцөнө. Сургалтын гэрээ, хэлэлцээр, төрөл бүрийн үнэлгээг ашиглана.
Үйл явцад суурилсан	Агуулгаас илүү сурах үйл явц (эргэцүүлэн бодох, мэдээлэл эрж хайх, боловсруулах зэрэг)-д голлон анхаардаг. Үнэлгээ нь өөрийн үнэлгээ, өөрийн сурах үйл явцыг эргэцүүлэн бодох зэрэг үйл явцад төвлөрнө.

Интеграцчилсан хөтөлбөр	Агуулгын интеграцчлалыг дэмждэг (ач холбогдолтой сургалт, спирал хөтөлбөр) загвар
Асуудалд суурилсан хөтөлбөр	Асуудлын шийдлийг ойлгоход чиглэсэн ажлын үйл явцаас гарч буй үр дүнгүүд.

Хүснэгт 5. Хөтөлбөр боловсруулах суралцагч төвтэй арга

Суралцагч төвтэй загварыг ихэнхдээ багш суралцагчийг мэдээлэлд тулгуурлан шийдвэр гаргах боломжтой болсон гэж үзсэн үед хэрэглэдэг. Гэсэн хэдий ч энэ загварыг зохих зааварчилгааны дор болон оюутны бүтээлч чадварыг хөгжүүлэх зорилгоор хэрэгжүүлж болох юм. Асуудалд суурилсан сургалтын загвар нь суралцагч ирээдүйд тун удахгүй нүүр тулах асуудал, бэрхшээлийг шийдвэрлэх шаардлагатай болох “бодит амьдрал”-ын нөхцөлүүдийг сургалтад хэрэглэхийг дэмждэг загвар юм.

Чадамжид суурилсан хөтөлбөр нь мэргэжлийн практиктэй шууд холбогддог, мэргэжил чухал гэж үздэг интеграл бүтэцтэй. Энэ хөтөлбөрт сурах үйл явц голлох үүрэгтэй, суралцагч төвтэй байдаг. Суралцагч төвтэй арга барил нь хүн бүрийн онцлогийг харгалзан үзсэн сургалтын арга барил хэрэглэх, сурах хугацаа уян хатан байх, суралцагчтай тасралтгүй эргэх холбоотой ажиллахыг шаарддаг. Суралцагч сурах үйл ажиллагаандаа өөрөө оролцох шаардлагатай. Харин чадамжид суурилсан хөтөлбөрийн хувьд, мэргэжлийн агуулга нь хөтөлбөр боловсруулах цорын ганц шалгуур биш, харин чадамжид түлхүү анхаарч, хөтөлбөрийн эцэст оюутнууд эзэмшсэн байх тэдгээр чадамжийг тодорхойлно.

Чадамжид суурилсан арга нь ерөнхий чадамжуудыг бүх хөтөлбөрөөр хөгжүүлж, тэдгээрийг “бодит амьдрал”-ын нөхцөлд хувиргана. Энэ арга нь инноваци, бүтээлч, асуудал шийдвэрлэх чадваруудад голлон анхаардаг ба оюутан өөртөө шаардлага тавьж, өөрийгөө үнэлж, сурах үйл ажиллагаагаа эргэцүүлэн бодох нь оюутны үндсэн үүрэг болж өгнө. Энэ загвар нь

- Мэргэжил, судлах хичээлийн функцийг тодорхойлох,
- Ерөнхий ур чадвар, чадамжийг хөгжүүлэх,
- Үнэлэх/дүгнэх арга бүхий “сурахад суралцах” чадавхи бий болгох гурван гол онцлогтой.

Дохи (Dochy), Никманс (Nickmans) нар 2005 онд чадамжид суурилсан хөтөлбөрийн 4 категорийг тодорхойлсныг доор харуулав:

КАТЕГОРИ	ТОДОРХОЙЛОЛТ
Зорилготой боловсрол, шинэ зорилтууд, сургах, сурахуйн шинэлэг арга барилууд	<ul style="list-style-type: none"> <li>• Мэргэжлийн дадлага/практик</li> <li>• Чадамжууд нь мэдлэг, ур чадвар, хандлага, “хэрхэн хийх вэ” гэж хуваагдана.</li> <li>• Мэдлэг, ур чадваруудыг олгоход түлхүү анхаарна.</li> <li>• Ерөнхий чадамжийг бүгдийг багтаасан байна.</li> <li>• Идэвхитэй сурахуйг чухалд үзнэ.</li> </ul>
Кейсээр дамжуулсан интеграцичлал	<ul style="list-style-type: none"> <li>• Мэдлэг, чадвар, хандлага тусдаа зорилтууд болж тодорхойлогдох хэдий ч мэргэжлийн дадлага ажилтай байнга холбогдож, интеграцчлал руу чиглэдэг байна.</li> <li>• Бодит, жинхэнэ нөхцөл байдлын хэрэглээ байна.</li> </ul>
Сурахуй ба хөгжлийн үе шат	<ul style="list-style-type: none"> <li>• Хөтөлбөрт сурах(хөгжлийн) арга замыг тусгасан байна.</li> </ul>

КАТЕГОРИ	ТОДОРХОЙЛОЛТ
	<ul style="list-style-type: none"> <li>• Чадамжуудыг зохион байгуулалттай, дэс дараатай хөгжүүлнэ.</li> <li>• Ерөнхий чадамжуудад анхаарна.</li> <li>• Нарийн төвөгтэй байдлыг нэмэгдүүлэх замаар багшийн чиглүүлэх, удирдах оролцоог багасгана.</li> <li>• Сурах үйл ажиллагаанд сургах нь гол зорилго байна.</li> <li>• Зөвхөн оюутны мэдлэг, чадвар, хандлагыг үнэлээд зогсохгүй, хувийн хөгжлийг ч мөн үнэлнэ.</li> </ul>
Эрэлтэд тулгуурлаж, чадамжийг хөгжүүлэхэд зорьсон	<p><b>Багшид чиглэсэн бус оюутанд чиглэсэн</b></p> <ul style="list-style-type: none"> <li>• Багшаас: нарийн төвөгтэй байдлыг дэмжсэн, чиглүүлэх оролцоог багасгах замаар бодит даалгаварууд /authentic tasks/ боловсруулна.</li> <li>• Оюутнаас: хувь хүний хөгжлийн төлөвлөгөө боловсруулах</li> <li>• Практик асуудлууд багшийн оролцоог бий болгодог.</li> </ul> <p><b>Эрэлтэд бүрэн тулгуурласан</b></p> <ul style="list-style-type: none"> <li>• Өргөн хүрээг хамарсан, нээлттэй даалгавар</li> <li>• Оюутан сургалтын асуултуудыг боловсруулах</li> <li>• Багшийн тусламжтайгаар оюутан хувийн хөгжлийн төлөвлөгөө болон түүнтэй холбоотой чадамжийн матрицыг боловсруулна.</li> <li>• Оюутан аль түвшинд аль чадамжийг хөгжүүлэх талаар тусгана.</li> </ul>

Хүснэгт 6. Чадамжид суурилсан хөтөлбөрийн 4 категори (Дохи, Никманс 2005)

ДБСБ-ууд аргацаах төдий сургалт явуулахаас сэргийлэх аргуудын нэг нь чадамжид суурилсан сургалт юм. Энэ нь академик боловсрол гэж юу вэ буюу дээд боловсролын хөтөлбөрөөс оюутнууд ямар академик чадамжуудыг эзэмших вэ гэдэг асуултад анхаарлаа хандуулсаар ирсэн.

Сургах, сурахуйн аргуудад түлхүү анхаарч эхэлснээр чадамжид суурилсан боловсролын олон төрлийн арга барилуудыг олж мэднэ. Жишээлбэл: асуудалд суурилсан сургалт, төсөлд суурилсан боловсрол, кейсд суурилсан сургалт, ажлын талбарт дадлага ажил хийх хосолсон сургалт гэх мэт.

Их сургуулийн төгсөгч дараах чадамжуудыг бүрэн эзэмшсэн байна. Үүнд:

- Шинжлэх ухааны нэг буюу олон чиглэлд ажиллах чадвартай: Их сургуулийн төгсөгч өнөөгийн шинжлэх ухааны талаар мэдлэгтэй, мэдлэгээ тэлэх, хөгжүүлэх чадвартай.
- Судалгаа хийх чадвартай: Их сургуулийн төгсөгч нь судалгааны ажил хийх замаар шинжлэх ухааны шинэ мэдлэг олж авах чадвартай байна. Энэ зорилгоор судалгаа гэдэг нь шинэ мэдлэг хөгжүүлэх, зорилготой, системтэй шинэ ойлголттой болох гэсэн утга юм.
- Төлөвлөх чадвартай: Их сургуулийн төгсөгч нь судалгаа хийхээс гадна төлөвлөх чадвартай байна. Төлөвлөлт нь урьдчилан тодорхойлсон хэрэгцээ, шаардлагын дагуу үнэ цэнийг бий болгох санаа бүхий шинэ болон шинэчилсэн бүтээгдэхүүн, системийг хэрэгжүүлэхээр зорьж буй хийсвэр үйл ажиллагаа юм.

- Шинжлэх ухаанч хандлагатай байна: Их сургуулийн төгсөгч нь шинжлэх ухааны онол, загвар, мэдлэгээ ашиглах, хөгжүүлэх системтэй арга барилтай, шинжлэх ухаан, технологийн талаар шүүмжлэлт хандлагатай байна.
- Оюуны суурь чадваруудыг эзэмшсэн байна: Их сургуулийн төгсөгч нь шүүмжлэлийн учир шалтгааныг олох, үнэлэх, дүгнэх чадвартай байна. Эдгээр чадваруудыг мэргэжлийн хичээлийн агуулгад тусган оюутнуудад заах, хөгжүүлэх замаар эзэмшүүлвэл зохистой.
- Хамтран ажиллах, харилцах чадвартай: Их сургуулийн төгсөгч нь бусадтай болон бусдын төлөө ажиллах чадвар эзэмшсэн байна. Энэ нь зөвхөн хамтран ажиллах төдий биш хариуцлага, бие даасан байдал, манлайллын талаар мэдлэгтэй, хамт ажиллагсад болон бусадтай сайн харилцаатай байхыг шаарддаг.
- Технологи ашиглах чадвартай: Өнөөгийн болон маргаашийн технологиор дамжуулан мэдээллийг зохион байгуулах, хөрвүүлэх чадвартай байна.

Эцэст нь загваруудын талаарх энэхүү хэсгийг дүгнэж “төгс загвар гэж байхгүй учраас нэг загвар бүх хөтөлбөрт тохирно гэж байхгүй юм” гэдгийг давтан хэлэхийг хүсч байна. Тухайлбал, зарим шинжлэх ухаан, эрүүл мэндийн хөтөлбөрүүдийн хувьд, эхний жилд шинжлэх ухаан, техникийн арга барилыг түлхүү хэрэглэх шаардлагатай бол хөтөлбөрийн төгсгөлд илүү практикт чиглэсэн арга барилыг ашиглах жишээтэй.

Портер(2005) болон бусад судлаачдын үзэж буйгаар хөтөлбөр нь Төлөвлөсөн, Хэрэгжсэн, Оюутанд хүрсэн гэдэг 3 хэлбэрт байдаг. Төлөвлөсөн хөтөлбөр нь их дээд сургуулиудын (бага, дунд сургуулиудад ч мөн хамааралтай) хэрэгжүүлэхээр зорьж, төлөвлөн, зохих журам, процедурын дагуу батлуулсан хөтөлбөрүүд юм. Энэхүү хөтөлбөрийг мөрдөн сургалтын үйл ажиллагаа явуулах бөгөөд үүнийг хэрэгжсэн хөтөлбөр гэж нэрлэдэг. Хөтөлбөрийг хэрэгжүүлсний дараа уг хөтөлбөрийн дагуу сурсан оюутны эзэмшсэн мэдлэг, чадварыг оюутны эзэмшсэн хөтөлбөр гэж нэрлэдэг. Хичээл сургалтын үйл ажиллагааны явцад хэрэгжилт төлөвлөлтөөс өөр байх, багшийн заах арга барил, сургалтын зохион байгуулалт болон бусад олон шалтгааны улмаас хэрэгжүүлсэн хөтөлбөрийг оюутан төлөвлөснөөс өөрөөр хүлээн авч эзэмших тохиолдол бас гарах боломжтой.

Дээрх гурван хэлбэрийн хөтөлбөрийн хоорондын зааг ялгааг хамгийн бага, цаашилбал огт байхгүй болгох нь дээд боловсролын системийн туйлын зорилт юм. Монгол улсын их дээд сургуулиудын хувьд сургалтын зохион байгуулалт, багш нарын арга барил, үнэлгээний ур чадвар, эдийн засаг, нийгмийн байдал зэрэг олон хүчин зүйлсээс хамааран дээрх гурван хөтөлбөрийн хоорондын ялгаа их байгаа. Хөтөлбөрийг оюутан төлөвлөсөнтэй ижил хэмжээнд эзэмшиж чадаж байгаа эсэхийг ч тогтоож чадахгүй байгаа сургуулиуд ч байгаа.

Энэхүү материалын хойших хэсэгт эдгээр гурван хэлбэрийн хөтөлбөрийн шат болгоны талаар дэлгэрэнгүй дурьдах болно.

### **3. ХӨТӨЛБӨРИЙН БОЛОВСРУУЛАЛТ, ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ**

#### **3.1 Хөтөлбөр боловсруулалт**

Үр дүнтэй хөтөлбөрийн загвар ДБСБ-д өөрийн боломжит нөөц бололцоог бүрэн ашиглахад тусалдаг, хөтөлбөрөө засах, боловсронгуй болгох үйл ажиллагааг нь хялбаршуулдаг.

Үр дүнтэй боловсруулагдсан хөтөлбөр дараах онцлогтой байх хандлагатай байдаг. Эдгээр нь:

- Тэнцвэртэй /well-balanced/: Хөтөлбөрт олон бүрэлдэхүүн хэсгүүдийг тохирох эзлэхүүнтэй оруулж өгсөн байх ба нэг нь ч өөрийн хуваарилагдсан эзлэхүүнээс илүү давамгай байдаггүй.
- Бүрэн, гэвч хэт ачаалалтай биш: Боломжтой нөөц бололцоог ашиглан гарах үр дүн. Хэт ачаалалтай хөтөлбөр оюутан нэгэнт бүгдэд нь оролцох боломжгүйгээс үүдэн аль хэсэгт оролцох уу, аль хэсгийг орхигдуулах уу гэсэн сонголттой тулгардаг. Ийм нөхцөлд аль нэг хөтөлбөрийг орхих шаардлагатай болдог.



- Уян хатан: Хөтөлбөр нь өөр өөр оюутны ялгаатай хэрэгцээнд нийцэхүйц, шинэчлэгдэж буй тэргүүлэх чиглэлд хариу үзүүлэхүйц, ирээдүйд өөрчлөгдөх магадлалтай мэргэжлийн шаардлагуудад бэлэн байдаг,
- Суралцагч өсөн дэвжих боломжтой: Оюутнуудыг програмаа дуусгах замаар өсөж, хөгжихийг дэмжих, ихэвчлэн тодорхой бүтэцтэй, заавал үзэх хичээлээс эхлэн сонгосон мэргэжлийн хичээл нь голлодог загварт шилждэг.
- Оюутан төвтэй: Хөтөлбөр гэдэг нь оюутан бүрийн ойлгодог ДБСБ-аас санал болгодог хичээл, ангиас илүү гүн гүнзгий, тухайн сургуульд суралцах хугацаандаа сурах, эзэмших бүх зүйлийн нэгдэл юм.
- Сурах үйл ажиллагаанд төвлөрсөн: ДБСБ сурах үйл явцыг хэрхэн сайн дэмжиж байгаа, хэрхэн үр дүнд хүрсэн гэдгийг харуулах шаардлагыг суурь болгон үнэлгээний болон сургалтын арга сонгодог.

ДБСБ хөтөлбөрөө бүх оюутны дунд амжилтыг хөхүүлэн дэмждэг байхаар боловсруулдаг байх нь чухал. Бүгдийг хамарсан хөтөлбөрийн загвар /inclusive curriculum/ нь оюутны боловсрол, соёл, нийгмийн мэдлэг, туршлагыг харгалзан үзсэн байдаг. Мөн сургах, сурахуйн тэгш байдлыг бататгах боловсролын чанар сайжруулах үйл явцыг ДБСБ-д бий болгох боломж олгодог. Энэхүү практик зааварчилгаа нь салбарын өргөн хүрээтэй үйл ажиллагаа, инновацийг нэгтгэж, хөтөлбөр боловсруулах үйл явцыг дэмжих үр дүнтэй стратеги, нийтлэг нөөц бололцооны жишээнүүдийг санал болгоно.

Хөтөлбөрийн дизайнд анхаарах нь урьдчилан төлөвлөх үйл ажиллагааг дэмжиж, дээд боловсролын сургалтад оролцогчдыг өөрсдийн сургах, сурах үйл ажиллагаанд урьдчилан бэлтгэдэг арга барил хэрэгжүүлэхийг зөвшөөрдөг. Тэгш байдал, хамтын ажиллагаа, уян хатан, хариуцлагад суурилсан хөтөлбөрийн загвараас багш, оюутан аль аль нь үр шим хүртдэг.

Дээд боловсрол олон улсын шинжтэй болж байгаа мөн гадаад оюутны тоо өсөн нэмэгдэж байгаа зэрэг нь сургах, сурахуйн талаарх бодлого, туршлагад шинэчлэл хийх гол хөшүүрэг болж байна. Байгууллагуудын хамтын ажиллагаанууд нь дээд боловсролын салбарт олон улсын түншлэл, хөтөлбөрийн чиглэлээрх харилцаа холбоог хөгжүүлэхэд чиглэж байна.

3

- Зорилгод тусгагдаагүй ямар нэг зүйлийг үнэлсэн үү? Яагаад?
- Үнэлээгүй орхисон зүйл зорилгод байсан уу? Яагаад
- Үнэлгээгээр үнэлэхийг зорьсон зүйлээ үнэлж чадсан уу?

### 3.2 Хөтөлбөрийн хяналт шинжилгээ

Тухайн ДБСБ эсвэл тэнхим аливаа хөтөлбөр, програмыг хянан шалгах аас өмнө одоо хэрэгжүүлж буй хөтөлбөр, програмуудад оруулсан өөрчлөлтүүд програмын өөрийн ерөнхий зорилго, зорилтуудтай нийцэж байгаа эсэхэд анхаарлаа хандуулах хэрэгтэй. Шинэ хөтөлбөр боловсруулах үйл явц нь системтэй хийгдэх ёстой. Сургууль/тэнхимийн багш нар хөтөлбөрийн үндсэн асуудлуудын талаар нэгдсэн ойлголтод хүрсэн байх нь чухал. Хөтөлбөрт хяналт шинжилгээ хийхээр шийдвэр гарсан тохиолдолд доор жагсаасан хэсгүүдийг зайлшгүй анхаарч үзэх шаардлагатай.

#### 1. Философи

Хөтөлбөр болон сургах үйлтэй холбоотой итгэл үнэмшил, ойлголт, үнэт зүйлээ тодорхойлно. Өөрийн алсын харааг нягтлах, мэргэжлийн магадлан итгэмжлэлийн шаардлагуудыг эргэн харах, багш нарын саналыг асуух замаар энэ процессыг эхлүүлж болно. Сургууль/тэнхим нь хөтөлбөрийн философийн талаар нэгдсэн ойлголттой болсон байна.

## 2. Оюутнууд

Хөтөлбөрөөр суралцаж буй оюутнуудын онцлог, нөхцөл байдлыг үнэлж, сургалт/хичээлийн агуулгыг тодорхойлоход шаардагдах онцлогуудыг жагсаана. Жишээлбэл, өөр өөр соёл бүхий орноос ирсэн англи хэлээр хоёрдагч хэлний хувиар ярьдаг оюутнууд, эсвэл гэр бүлийнхээ өмнө хариуцлага хүлээдэг оюутан гэх мэт. Мөн хөтөлбөрт нөлөөлөхүйц оюутны хүйс болон бусад онцлогуудыг харгалзан үзсэн байна.

## 3. Зорилго, зорилтууд

Хөтөлбөрийн зорилго, зорилтуудыг жагсаана. Энэ жагсаалтад оюутан хөтөлбөр, их сургуулийг төгсөх үед эзэмшсэн байх мэдлэг, ур чадвар, чадамжийг багтаасан байна. Жишээлбэл:

- Оюутан өөрсдийн мэргэжлийн хүрээний судалгааны ажлуудад шүүмжлэлтэй хандах чадамжтай байх
- Оюутан компьютерийн загварчлалыг боловсруулах, хэрэгжүүлэх чадамжтай байх

## 4. Бүтэц, дэс дараалал

Програмын хичээл тус бүрийг бие даасан зорилго, зорилт нэг бүрт оруулах хувь нэмрийг тодорхойлох зорилгоор нягтлана. Хөтөлбөр дэх хичээл хоорондын харилцаа, хичээл хөтөлбөрийн ерөнхий зорилгуудад хэрхэн чиглэж буйг харуулсан шаталсан диаграм эсвэл график боловсруулах хэрэгтэй. Ингэснээр хөтөлбөрт байгаа логикгүй дараалал, илүүдэл, алдаа (жишээлбэл, хөтөлбөрийн зорилгыг аль нэг хичээлийн турш анхаарч үзэхгүй орхих гэх мэт)-г илрүүлж, хичээлийн силабуст шаардлагатай байгаа өөрчлөлтөд анхаарлаа хандуулах боломжтой болно.

## 5. Сургалтын аргууд

Хичээл бүрт ашигласан сургалтын аргуудыг ашигласан материалын хамт жагсаана. Үүнд дараах мэдээллүүдийг оруулна: 1) лекц, асуулга, 2) групп ажил, 3) онлайн хэсгүүд (хэрэв байвал), 4) номын сангаар унших ном, 5) сурах бичгүүд, бие даан судлах номууд. Суралцагчдын хэрэгцээ болон хөтөлбөрийн зорилго, зорилттой нийцэж байна уу гэдэгт үндэслэн эдгээр сургалтын аргад анализ хийнэ. Энэ хэсгийн гол анхаарах зүйл нь сургалтад ашиглаж буй арга, хэрэглэгдэхүүн сургалтаас хүлээгдэж буй үр дүнд нийцэж буй эсэхийг нягтлах явдал. Хэрэв оюутнууд тодорхой ур чадвараа харуулахаар хүлээгдэж байгаа бол тэдэнд тухайн ур чадвараа хөгжүүлэх боломжийг олгосон байх шаардлагатай.

## 6. Сурах үйл явцыг үнэлэх

Багш оюутныг үнэлэхэд ашигладаг арга, аргачлалаа жагсаана. Жишээлбэл, 1) эссэ, 2) олон сонголт бүхий тест, 3) багаар ажиллах, 4) бие даалт гэх мэт. Эдгээр арга, техникүүдийг нийт оюутнуудын хэрэгцээнд нийцсэн эсэх, сургалтын арга, хэрэглэгдэхүүнтэй тохирч байгаа эсэх, хөтөлбөр болон их сургуулийн өргөн хүрээний зорилготой таарч байгаа эсэхэд дүн шинжилгээ хийнэ. Үнэлгээг зөвхөн хичээл, програмын агуулгад биш, хүлээгдэж буй сургалтын орчин, хэлбэрт ч хамааруулна.

## 7. Сургах үйл явцыг үнэлэх

Хичээл/хөтөлбөрийн сургалтын үр нөлөөг хэрхэн үнэлэх вэ? Энэ нь сургалтын үнэлгээний адил хөтөлбөрийн гол хэсэг юм. Эдгээр техникүүдийг жагсаасан байна. Жишээлбэл: 1) оюутан сургалтыг үнэлэх, 2) оюутны ажлыг үнэлэх, 3) санал, захидал, бичлэг, 4) хичээлийн агуулгыг мэргэжлийн түвшинд хянах гэх мэт. Програмд өөрчлөлт оруулах, боловсронгуй болгох зорилгоор тэнхим/сургууль програмын бүх хэсэгт тогтмол, системтэй хяналт тавьж байгаа эсэхийг бататгах шаардлагатай.

## **4 ХӨТӨЛБӨРИЙН ШИЛДЭГ ТУРШЛАГУУД**

Судалгаа, эрдэм шинжилгээний олон өгүүлэлд дурдсанаар дээд боловсролд элсэн орсон оюутнуудын амжилт, гүйцэтгэлд нөлөөлөх гол хүчин зүйлүүд нь хөтөлбөр, сургах, сурахуй юм гэж тодорхойлжээ.

Дэлхийн олон улс орон өөрийн дээд боловсролын салбарыг шинэчлэхдээ Монгол улсын хэдэн жилийн өмнө эхлүүлсэнтэй ижил аргыг ашигласан байдаг. Хөтөлбөр, сургах, сурах үйл ажиллагаа нь ДБСБ-уудын эхлүүлсэн шинэчлэлийн үйл ажиллагааны чухал хэсгүүд юм. Тийм ч учраас ДБСБ-ууд бусад улс оронд хийсэн шинэчлэл, санаачлагуудтай харьцуулах замаар өөрсдийн хөтөлбөрийг боловсруулж, хэрэгжүүлж, үнэлж, оновчтой хэлбэрүүдийг өөрсдийн онцлогт нийцүүлэн хэрэгжүүлсэн байдаг.

Энэ хэсэгт хөтөлбөрийн тэргүүн туршлага, сурсан сургамж, түүнчлэн цаашид юу хийх шаардлагатайг тоймлон оруулав. Хөтөлбөрийг хянах нотолгоонд суурилсан процес, үр дүнгүүд нь хөтөлбөртөө томоохон өөрчлөлт оруулахтай холбоотой гол шийдвэрүүдийг гаргахад үнэлгээний мэдээлэл, түүнд хийсэн дүн шинжилгээ ихээхэн чухал болохыг ДБСБ-д ойлгуулдаг. Доорх жишээнүүд нь энэхүү ойлголтоос бий болсон, их сургуулиуд өөрсдийн шинэ хөтөлбөрүүдэд тусгасан, Монголын ДБСБ-уудад хэрэгжүүлж болохуйц туршлагууд юм.

Хамгийн анхны судалгааг Австрали улсад шүдний эмчийн сургалтын хөтөлбөрийн хүрээнд хийсэн бөгөөд эрүүл мэндийн боловсролтой холбоотой дэлхийн туршлагуудын элементийг судлан үзэж, шинэ хөтөлбөртөө тусгасан. Судалгаагаар эрүүл мэндийн чиглэлийн боловсролд сайтар боловсруулагдсан уламжлалт арга барилууд нь оновчтой үзэл баримтлалын загвар болон дээд боловсролын цөм хэрэглээгээр дэмжигдэж амжилттай хэрэгждэг болохыг тодорхойлсон байна. Судалгаанд VILS (Vermont's Inventory of Learning Styles) буюу дараах сурах үйл ажиллагааны 4 загварын алинд оюутнууд илүү ач холбогдол өгч байгааг хэмждэг судалгааны хүчин төгөлдөр аргыг (хэрэгсэл) ашигласан. Эдгээр нь: (1) утгад чиглэсэн-гүн арга барилууд: хувийн зохицуулалт, сурахуйг хувийн зохион байгуулалт гэж үздэг; (2) нөхөн үйлдвэрлэлд чиглэсэн-өнгөц арга барилууд: гадаад дүрэм, журмаас хамааралтай, сурахуйг мэдлэгээ хэрэглэх, боломжоо харуулах хүсэл гэж үздэг; (3) чиглэлгүй-хувийн зохицуулалт муу, сурах чиг хандлага хоёрдмол, ач холбогдлоо гадаад эх үүсвэрт хандуулсан; (4) хэрэглээнд чиглэсэн-мэргэжлийн хүчтэй чиг баримжааг сурахуйд олгодог, сурахуй бол мэдлэгийн хэрэглээ гэж итгэдэг 4 сурахуйн загвар юм.

Улс орон бүрт өөр өөр хувилбарууд байсан нь тодорхой ч, цөм чадамжийн бүрэлдэхүүнд харилцааны чадвар, ёс зүй, өвчтөн төвтэй үйлчилгээ, эм ашиглалтын тогтолцоо зэрэг нийтлэг шинжүүдийг багтаасан байна. Судалгааны үр дүн ДБСБ-ууд өөрсдийн хэрэгжүүлж байгаа хөтөлбөр, програмд хяналт тавих, шинэ хөтөлбөр боловсруулахад тодорхой удирдамж болж чадах юм. Судалгааны үр дүнгүүдийг дурдвал:

1. Хөтөлбөрийн спирал бүтцийг хичээлийн агуулгын босоо, хэвтээ интеграцийн хамт авч үзэх. Үүний гол онцлог нь хөтөлбөр төлөвлөлтийн Хардений загвар (Harden's SPICES-Оюутан төвт, асуудалд тулгуурласан, интеграцчилсан, олон нийтэд чиглэсэн, сонголттой, системтэй) байдаг.
2. Сургалтаас хүлээгдэж буй үр дүнг тодорхойлох. Энэхүү жагсаалтаар жил бүр, сургууль төгсөхдөө оюутны эзэмшсэн байх мэдлэг, чадвар, ёс суртахууны хэм хэмжээг дэлгэрэнгүй тодорхойлсон байдаг. Жагсаалтад Биггсийн СОЛО(SOLO-Structured Observation of Learning Outcomes) таксономи дах танин мэдэхүйн нарийн түвэгтэй байдлыг тусгасан байх шаардлагатай.
3. Сургалтын үр дүн, сургалтын үйл ажиллагаа, үнэлгээний ажлуудыг холбосон оновчтой зохицуулалт байх. Энэ нь дээр дурдсан Harden's SPICES загварын зохион байгуулалттай элементийн нэг онцлог юм.

Латтука, Старк (Lattuca and Stark) нар 2009 онд санал болгосон загвараа Америкийн ДБСБ-уудын хэрэгжүүлдэг дээд боловсролын байгууллагуудын сайн чанарын, нийтэд зөвшөөрөгдсөн олон төрлийн хөтөлбөрт суурилсан боловсруулсан байдаг. Хөтөлбөрийн болон багшийн чанарыг сайжруулах нь өргөн хүрээний үйл ажиллагаа байх нь тодорхой. Хөтөлбөр, багшийн чанар

сайжирснаар сургах үйл явц, оюутнуудын сурах үйл ажиллагаанд ч эерэгээр нөлөөлдөг. Эдгээр нь дор дурдсан санаачлагуудыг багтааж болно.

- Сургахуй, сурахуйг хөгжүүлэх төв
- Үр дүнд суурилсан хөтөлбөр
- Хөтөлбөрийн загвар, хяналт, үнэлгээн дэх багш нарын оролцоо
- Мэргэжлийн хөгжлийн үйл ажиллагаанууд (багш нарт зориулсан багш бэлтгэх сургалт гэх мэт)
- Амжилтыг урамшуулах зорилготой өрсөлдөөн, шагналын систем
- Багшийн инновацийн сан
- Багш сонгон шалгаруулах шалгуур
- Багш, суралцагч нарын холбоод
- Сургах, сурах үйл ажиллагааны зохион байгуулалт, удирдлага
- Оюутны амжилтыг дэмжихэд туслах (зөвлөн туслах, мэргэжлийн зөвлөгөөгөөр хангах, чиглүүлэх зэргээр)
- Оюутны үнэлгээ (ө.х програм болон сурлагын чанарт өгөх үнэлгээ)
- Өөрийн үнэлгээ, хөндлөнгийн үнэлгээ, жишиг туршлагууд
- Олон нийтийн үйлчилгээ болон ажилд тулгуурласан програм, хөгжилд суурилсан хөтөлбөр

Хөтөлбөрүүдийг шинэчлэх аргуудыг хэрэгжүүлэхэд, хөтөлбөрийн хороод болон байгууллагын холбогдох ажилтнууд дараах шаардлагуудыг харгалзан үзнэ.

- Сүүлийн үеийн боловсролын чиглэлийн судалгаа, заах арга зүйн шилдэг туршлагуудын талаар тогтмол мэдээлэл авдаг байх,
- Багш нар судалгаа зонхилсон сургалт, оюутныг идэвхижүүлэх арга барил, олон төрлийн мэргэжлийн чиглэлийн чиг хандлагуудад суралцах сонирхолтой байх,
- 
- Хөтөлбөр, сургах, сурах үйл ажиллагааг хариуцдаг хүмүүсийг туслалцаагаар хангах сургалтын загвар маш чухал. Тодруулбал, нэгж хэсгүүдийн загвар гаргах (лекц, хичээл, практик болон вэб туслалцааны элементүүдийг холбох); оюутнуудад зааж буй хичээлийн хамаарлыг харуулах; агуулгатай холбогдсон, үнэлэгдэхүйц сургалтын үр дүнг тодорхойлох; өөрөө чиглүүлдэг сурахуйг сайжруулах; лекцээр үед оюутнуудтай харилцах, хариу өгөх аргууд, эрсдэлд байгаа оюутныг хэрхэн олж, асуудлыг шийдвэрлэх зэрэг нүүр тулсан сургалтын арга техникээ сайжруулахад практик туслалцаагаар хангаж болох юм.
- Багш нарын хамтын ажиллагаа эсвэл хичээлийн тогтвортой байдал нь амжилтад хүрэхэд чухал үүрэгтэй. Тиймээс ДБСБ багш нарт үр дүнтэй хамтран ажиллах боломжийг бүрдүүлж өгсөн байна. Энэ нь өмнөх хичээлийн жилийн сургалтын хэрэглэгдэхүүнийг дахин ашиглах боломжтой байх, бие биенийхээ одоо ашиглаж буй сургалтын хэрэглэгдэхүүнтэй танилцах боломжтой байх гэсэн үг юм.
- Хөтөлбөр боловсруулагчид, багш нар өөрийн сургах үйл ажиллагаагаа сайжруулах, сурах үйл ажиллагааг дэмжих сонирхолтой байх гэдгийг дараах байдлаар ойлгож болно. Суралцагчид хүсэл сонирхолдоо тулгуурлан мэдлэгээ ахиулдаг учир хичээлийн агуулгад шалгалтын даалгавар, тодорхой хугацаанд хийж гүйцэтгэх ажлуудыг оруулж өгөх хэрэгтэй. Оюутнууд сурах үйл явцыг чиглүүлж өгөх хөндлөнгийн туслалцаа, журамд тулгуурлах хандлагатай байдаг учраас үр дүнтэй сурах, сургах арга зүйг бүрдүүлдэг оюутан, тэнхимийн хоорондын зайг багасгах шаардлагатай юм. There is a need to craft learning

environments and activities that incorporate practice applications to stimulate curiosity and motivate students to take charge of and actively engage in their learning.

2003 онд Бигс (Biggs) Англи улсын хөтөлбөрийн боловсруулалт, хяналт, үнэлгээний туршлагауудыг тоймлон танилцуулсан. Тэрээр хөтөлбөрийн боловсруулалт, сургахуй, сурахуй нь ДБСБ-уудын амжилтад мөн суралцагчдын суралцах үйл ажиллагаанд зайлшгүй шаардлагатай. Хөтөлбөр, сургахуй, сурахуйн талаарх чиг хандлага нь шинэ харилцаа шаардлагатай шинэ парадигмд тулгуурласан байна. Сургалтын модель, загваруудын хүрээнд өргөн харилцаа, хамтын ажиллагаа байх шаардлагатай. Бигс их сургуулийн сургалтын үйл ажиллагааг сайжруулах зөвлөмждөө дараах зүйлсийг багтаажээ. Үүнд:

- Заах арга зүйг судалгаатай илүү хүчтэй холбох
- Хөтөлбөрүүдийг дахин загварчлах
- Сургалтын шинэлэг платформуудыг бий болгох
- Оюутны болон багшийн ачааллыг дахин авч үзэх
- Сурган заах арга дах тасралгүй сайжруулалт, технологийн хэрэглээ, оюутан төвтэй сургалтад нийцсэн үнэлгээний загварууд
- Шинэ арга барил, хэрэглэгдэхүүний талаар оюутнуудыг зааварчилгаа, чиглэл, удирдлагаар хангаж, хичээл заах
- Үр нөлөөг үнэлж, сургалтын үр өгөөжийг баримтжуулах
- Суралцагчдыг бүтээлчээр сурах, дадлага хийх боломжийг авч үзэх зэрэг болно.

Шинэ санаачлага, урагш тэмүүлэх чанар нь ирээдүйн боломжууд гэж дэлхийн мэдлэгт суурилсан эдийн засагт тодорхойлсон байдаг. Шинэчлэгдсэн ДБСБ-уудын хамтын зорилго/хүч нь нийгмийн тогтвортой хөгжил, маргаашийн хөгжил цэцэглэлтийг дэмжинэ. Өнөөгийн нийгэм дэх ДБСБ-уудын олон улсын оролцоо нь ДБСБ-уудын эн тэргүүнд тавих асуудал байна. Хөтөлбөр боловсруулахдаа түүний агуулга болон нийгмийн бодит байдлыг авч үзсэн байна. Нийгмийн төрөл бүрийн онцлогтой түншлэлүүд нь хөтөлбөр боловсруулах үйл явц, заах арга зүйг тогтмол сайжруулж, боловсронгуй болгоход чухал ач холбогдолтой. Бигсийн дүгнэснээр сургахуй нь идэвхитэй, хувиран өөрчлөгддөг, “бодит амьдрал”-ын нөхцөлтэй холбогддог үйл явц юм.

Дээд боловсролын мэргэжилтнүүд сургахуйн бусад загваруудын талаар ч ярьсаар ирсэн. Сүүлийн арван жилийн турш АНУ, Канад улсын дээд боловсролын олон судлаачид, үндэсний нөлөө бүхий тайлангуудад “уламжлалт боловсрол олгох үйл явц нь өнөөгийн ажил олгогчдын тавьж буй шаардлагад нийцсэн, цаашлаад үнэ цэнэтэй иргэнд байх цогц чадамжийг оюутанд олгож чадахгүй байгаа”-г баталсаар ирсэн. Үндсэндээ уламжлалт онолын боловсрол олгох үйл явцаас судалгаа, онолд суурилсан үйл явцад шилжих нь зөвхөн сургалтын шинэ арга барилтай нийцүүлэн байнгын шинэчлэлийг шаардаад зогсохгүй энэ шинэчлэлийг дэмжих багш, ажилтныг мэргэжлийн хувьд хөгжүүлэхийг шаарддаг. Бидний судалгаагаа түшиглэсэн Хойд Америкийн их сургуулиуд аль алинд нь нөлөөлөхүйц чиг хандлагуудыг ойрын хэдэн жилд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байв. Ингэснээр багшийн хөгжил нь байгууллагын чанарыг дээшлүүлэхэд голлох үүрэгтэй оролцоно.

Их сургуулийн сургах үйл ажиллагааг сурах үйл явцын болон оюутны хөгжил, оюутанд үзүүлэх их сургуулийн үр нөлөө, сурах үйл ажиллагааны менежментийн эмпэрик судалгаа, эрдэм шинжилгээний ажлаас олж авсан бат бөх мэдлэгтэй мэргэжил гэж үзэх байдал нэмэгдсээр байна. Профессорууд дээд боловсролын мэргэжилтэн төдийгүй нэг ба түүнээс дээш салбарын агуулгын талаар онол, практикийн хангалттай суурь мэдлэгтэй байх шаардлагатай болно.

Оюутны эзэмшихээр хүлээгдэж буй үр дүнгүүд өнөөдрийнхөөс илүү чухал байр суурь эзэлнэ. Ингэснээр оюутнуудад 1) эргэцүүлэн бодох, асуудал шийдвэрлэх, учир шалтгааныг олох зэрэг оюуны өндөр чадамжууд; 2) өөрийгөө үнэлэх, бүтээлч байх, бусадтай харилцах, багаар ажиллах зэрэг чухал бүрэлдэхүүн хэсэг бүхий танин мэдэхүйн болон сэтгэхүйн чадамжийг бүрэн эзэмшүүлэх байдлаар сургалтын үр дүнг өргөжүүлнэ. Эдгээр үр дүн, гарц нь хамтдаа маргаашийн нийгэмд онцгой хувь нэмэр оруулах, байгууллагыг өөрчилж чадах “цогц бие хүн”-ийг хөгжүүлэхэд чиглэнэ.

Эдгээр өөр хоорондоо ялгаатай, цогц, “хөгжүүлэхэд үргэлж хэцүү байдаг” үр дүнд хүрэхийн тулд багш нар өөрсдийн сургалт, зөвлөх үйлчилгээг оюутан бүрийн хэрэгцээнд нийцүүлэх эмпэрик сэтгэл зүйн судалгаанд тулгуурлан оюутны хөгжлийн онолыг хэрэглэнэ. Ингэхдээ оюутнууд болон тэдний боловсролын үйл явцыг ойлгох, сурах үйл явцыг сайжруулах оролт, үйл явц, үр дүнгийн үнэлгээний аргуудыг ашиглан ангийн судалгаа авах шаардлагатай.

Өнөөдөр ч, цаашид ч багшийг боловсрол олгогчийнх нь хувьд сурах үйл явцад үзүүлэх үр нөлөөг нь бататгах олон төрлийн шалгуур, үзүүлэлтийг ашиглан оролт, үйл явц, гарцын үнэлгээний үр дүнд тулгуурлан үнэлэх явдал өссөөр байх болно. Багшийн үнэлгээ чанарт голлон анхаарч, мэргэжлийн чиглэлээрх тэргүүн туршлагаас хөтөлбөрийн загвар гаргах, сургах, зөвлөх, чиглүүлэх үйл ажиллагаандаа хэрхэн тусгаж байгаад голлон анхаарна. Түүнчлэн, хүрэхээр тодорхойлсон үр дүнгийн зорилго, зорилт, суралцагчдын онцлогт тохирохуйц боловсролын бусад үйл ажиллагааг багтаасан байна. Байгууллагын болон бие хүний үнэлгээг өмнө байснаас ч илүү чухал гэж үзэх бөгөөд хариуцлагын бүх хэмжүүр, хүчин чармайлт өсөн нэмэгдсээр байх болно.

Канадын дээд боловсролын хөтөлбөр, багшийн хөгжлийн мэргэжилтнүүдийн нэг Вольф 2007 онд хөтөлбөр боловсруулах загварын гол элементүүд/онцлогуудыг танилцуулсан. Түүний танилцуулсан арга нь багшаар удирдуулсан /faculty driven/, мэдээлэлд тулгуурлсан/data-driven/ боловсролын хөгжлийг дэмжсэн үйл явцад суурилсан. Энэ нь багш програмын зорилт болон үр дүнг тогтмол судалдаг соёлыг бий болгох, дэмжих үйл явцаас бүрддэг. Амжилттай байхын тулд түүний үр нөлөөнд чухал байх элементүүдийг жагсаасан. Энэ загварыг хэрэгжүүлж эхлэхэд, ДБСБ хамгийн багадаа нэг “аварга” багштай эхлүүлэх хэрэгтэй гэж санал болгосон. Хөтөлбөрийг шинэчлэх үйл явцтай холбоотой хамгийн чухал зүйл нь энэхүү үйл явцыг удирдах чин эрмэлзэлтэй, програмын хүрээнд ажиллаж, багш нарыг холбох, загвар гаргахад туслах, мэдээллийг цуглуулах, хэрэглэх, үйл явцыг үргэлж чиглүүлэх хамгийн багадаа нэг програмын гишүүн /program faculty member/ байна. Ихэнх практикт энэ хүн нь програмын хөтөлбөрийн хорооны дарга байдаг, энэ хүнээр дамжуулан хөтөлбөр шинэчлэх үйл явцад хөтөлбөрийн хороо тэргүүлэх үүрэгтэй оролцдог. Мөн хөтөлбөр хэрэгжүүлэгч буюу боловсрол хөгжүүлэгчийн үйлчилгээтэй холбохыг Волфийн нэмж санал болгосон. Багшаар удирдуулсан хөтөлбөрийн шинэчлэлийн үйл явцыг дэмжих хөндлөнгийн боловсрол хөгжүүлэгчийг ашиглах нь маш үр дүнтэй. Хөндлөнгийн боловсрол хөгжүүлэгчийг чиглүүлэгчээр ажиллуулах нь хэд хэдэн үр ашигтай, тухайлбал, хичээлийн загвар боловсруулах, өөр өөр сэдэв, агуулга дах хөтөлбөрийн туршлагауудын талаар ойлголттой болох, дээд боловсролтой холбоотой сургах, сурахуйн онол, практиктай танилцах зэрэг үйл явцад туршлага нэмэгддэг.

Багшаар удирдуулсан, мэдээлэлд тулгуурласан /faculty-driven, data-driven/ хөтөлбөрийг боловсруулах үйл явцыг маш болгоомжтой хийх хэрэгтэй. Энэ нь боловсролын чадварлаг мэргэжилтэн ном эсвэл ажлын дэвтэртэйгээ тэнхим рүү явж ороод шийддэг асуудал биш юм. Харин түүний үндсэн үүрэг бол үйл явц зогсонги байна уу, эсвэл урагшилж байна уу гэдгийг нягтлах явдал байдаг. Боловсролын мэргэжилтний гүйцэтгэх үндсэн ажлууд нь өөр хоорондоо ялгаатай үзэл бодолд хүндэтгэлтэй хандах, түүнийг анхаарч үзэж байгааг нягтлах, тухайн орны болон илүү өргөн хүрээний соёлын асуудал, боломжуудын талаарх ойлголтыг бий болгох, хөтөлбөр болон боловсролтой холбоотой арга барилуудын талаар мэргэжлийн экспертиз санал болгох, судалгаа, хөгжлийн ажлаар хангах зэрэг болно.

Түүнчлэн, ДБСБ хөтөлбөр боловсруулахдаа мэдээллийг үндсэн суурь болгон ашиглах шаардлагатай. Хөтөлбөрийн үнэлгээ, төлөвлөлтийн үйл явцын аль алинаас нь авсан мэдээлэл багш, тэнхимүүдийн талаар маш ач холбогдолтой мэдээллээр хангадаг. Энэхүү мэдээллийн үнэ цэнэ нь хуралд илтгэл тавихаар оролцох, хамтран ажиллагсадтайгаа програмаас гадуурх сэдвээр санал бодлоо солилцох, сургалтын агуулгад богино хугацаанд дүн шинжилгээ хийх боломжийг багшид олгодог. Эдгээр үйл ажиллагаа нь шинэлэг, үндэслэл сайтай хөтөлбөрийн сонголт руу хөтөлдөг. Хөтөлбөр боловсруулах үйл явц дах оролцоог тасралтгүй сайжруулах үйл явц гэж харах ёстой. Энэ загварын бүх үе шатыг хэрэгжүүлж дуусахад хөтөлбөрүүдэд нэг жил хүртэл хугацаа

шаардагддаг. Нэгэнт санаа /idea/ хэрэгжсэн бол үнэлэх, тохируулах үйл ажиллагааг хэрэгжүүлж эхэлнэ, түүний дараа хөтөлбөрийн үнэлгээг цогц байдлаар хийнэ.

Хөтөлбөр боловсруулах үйл явцад оролцох нь өөрийн хөтөлбөрийг тогтмол, маш нарийн шинжилж байдаг хөтөлбөрийн соёлыг бий болгоход ДБСБ-д тусалдаг. Энэ арга барил нь их үр дүнтэй байдаг. Учир нь багшид хөтөлбөр, хичээлийн дараагийн түвшинд шаардагдах өөрийн чадавхийг хэрхэн хөгжүүлэх талаар сургалтын дизайн, экспертизээр хангаж өгдөг.

Эдгээр цөөн хэдэн жишээ нь бидэнд Монголын улсын нөхцөлд тохируулан хэрэгжүүлж болохуйц зарим загваруудын зураглалыг бий болголоо. “Хөтөлбөр, сургахуй, сурахуй” нь байгууллагын алсын хараа, эрхэм зорилгын “зүрх” байх бөгөөд түүний ач холбогдлыг дутуу үнэлж болохгүйг ДБСБ-ууд сайтар ойлгох шаардлагатай. Хөтөлбөрийн үр дүн, сурах арга барил дах хүчин чармайлтыг анхаарснаар багш, сургуулийн удирдагчид ихээхэн үр шим хүртээд зогсохгүй, сургуулийн үйл ажиллагаанд онцгой ач холбогдолтой. Энэ үйл явц нь уламжлалт арга барилаас ирээдүйд оюутнуудыг бэлтгэхэд шаардагдах үр өгөөжтэй хөтөлбөр, сургах, сурахуйн шинэлэг, шинэ арга замуудад шилжиж буйтай уялдуулан сургалтын арга барилаа өөрчлөхийг шаардана. Эцэст нь, ДБСБ-ууд дах ямар ч томоохон өөрчлөлтийн салшгүй хэсэг нь удирдлага байх ёстой.

XX зууны сүүлийн арван жилүүдэд хийгдсэн хөтөлбөрийн олон шинэчлэл, сайжруулалтаас гурван гол өөрчлөлтийг онцолбол: (1) агуулгыг бүрэн эзэмшүүлэхэд голлон анхаардаг сургалтын зорилгоос чадамжийг өргөн хүрээнд эзэмшүүлэх зорилгод шилжсэн; (2) Суралцахуйн салангид хэлбэрээс хөтөлбөр хооронд шилжин сурах интеграцчилсан хэлбэрт шилжсэн, (3) Хичээлийн сэдэв нь гол гэж үздэг хэлбэрээс хөтөлбөрийн шинэчлэлийн чухал хэсэг болох сургалтын арга, үнэлгээний шинэ санаачлагуудад шилжсэн.

Мөн төгсөгчид өөр өөр үндэстний хүмүүстэй харилцах, олон улсад өрсөлдөх чадвар эзэмшсэн байх нь бакалаврын хөтөлбөрийн гол анхаарах асуудал болсон.

## **5 ХӨТӨЛБӨРИЙН ҮНЭЛГЭЭ, ХЭРЭГЖҮҮЛЭЛТ**

### **5.1 Хөтөлбөрийн үнэлгээ**

Хөтөлбөрийн ажил яагаад хүндрэлтэй байдгийн нэг шалтгаан нь энэ ажил өмнө нь огт хийгдээгүй байдаг. Тэнхим, багш эсвэл хөтөлбөрийн хороо хөтөлбөрийг боловсруулмагц, хөтөлбөрийн агуулга дах сургах, сурах үйл ажиллагаа нь оюутнууд амжилт гаргахад тусалж чадах эсэхийг бататгах тийм үйл явцуудыг хэрэгжүүлэх нь чухал байдаг. Судалгааны ажлууд, холбогдох баримт бичгүүдэд дурдсанчлан, хөтөлбөрийн үнэлгээ, дүгнэлт нь амжилтын гол хөшүүрэг байдаг. ДБСБ-ууд өөрийн хөтөлбөрүүдийг үнэлж, дүгнэхэд ашиглах процедур, үйл явцын журам, зарчмыг боловсруулсан байх шаардлагатай.

Үнэлгээний болон хяналтыг хэрэгжүүлэх гол үндэслэл нь чанартай хөтөлбөр гэж юу вэ гэдгийг тодорхойлоход оршино. Уг тодорхойлолтыг гаргахад туслах гол элементүүд нь:

- Байгууллагын эрхэм зорилготой уялдсан байна;
- Хүрэх үр дүнг сайтар тодорхойлсон байна;
- Суралцагч бүрт тэдгээр үр дүнд хүрэхэд туслах сургалт, практикийн хамгийн сайн хослолыг ашиглах;
- Үр дүнд хүрсэн эсэхийг харуулах үнэлгээний процесийг багтаасан байна;
- Хөтөлбөрийн үр нөлөөг сайжруулахад үнэлгээний дүгнэлт, үр дүнг ашиглах.

Ихэнх тохиолдолд, ДБСБ-ын удирдлага, багш нар, захиргааны ажилтнууд өөрийн үнэлгээ болон хяналт шалгалтыг бүлэг асуултанд хариулах хэлбэрээр гүйцэтгэдэг. Эдгээр асуултуудыг дээд боловсролын хөтөлбөрүүдийг боловсруулах, хэрэгжүүлэх үйл явц, түүний төрөл бүрийн шинж чанарыг үнэлэхэд ашиглах зорилгоор тусгай индикатор хэлбэрээр боловсруулж, хэрэглэж болох юм.

Боловсролын салбарт хэрэглэгддэг үнэлэх, хянах гэдэг хоёр үгийн аль алины агуулгыг тодорхойлж чадах индикатор, шалгуур үзүүлэлтүүдийн талаар судалж үзье. Шалгуур үзүүлэлт нь “дүгнэлт, шийдвэрт суурилсан стандарт, дүрэм, эсвэл тест” гэсэн утга илэрхийлдэг бол, индикатор нь “явцыг ажиглах, бодит үр дүнг хэмжиж хүлээгдэж буй үр дүнтэй харьцуулах”-д хэрэглэгдэнэ. Гүйцэтгэлийг үнэлэх индикаторууд ихэвчлэн тоон нэр томъёогоор илэрхийлэгдсэн, зорилтот, хэмжигдэхүйц байдаг.

Үнэлэх болон хянах үйл явцад хэрэглэгдэж болох 5 үндсэн санааг хэд хэдэн тоон болон чанарын үзүүлэлтүүд буюу шалгуур үзүүлэлтийн хамт санал болгосон байдаг.

**A. Алсын хараа, зорилго, зорилтууд (Зорилго болон хүсч буй үр дүнг маш нарийн тодорхойлсон байна)**

- Тэнхимийн, сургуулийн, байгууллагын алсын харааны хүрээнд хөтөлбөрийн уялдаа холбоо, урсгал
- Шинээр элсэн орж буй оюутнуудын хөгжлийн түвшин, мэдлэг, ур чадвар, сэтгэл зүйн онцлогын үнэлгээ, норм
- Оюутнууд төгсөхдөө эзэмшсэн байхаар хүлээгдэж буй мэдлэг, ур чадвар, хандлага, үнэ цэнийг тодорхойлсон сургалтын үр дүнгүүд,
- Оюутан, багш, удирдлагад ижил ойлголт өгөхүйц ойлгомжтой, тодорхой бичсэн хүрэхээр төлөвлөж буй үр дүнгүүд ,
- Оюутнуудын амжилтыг үнэлж болохуйц үр дүнтэй зорилго, зорилтын хүрээнд хүрэхээр төлөвлөсөн үр дүнгүүд,
- Тэдгээр хүрэхээр төлөвлөсөн үр дүнгүүдийг тодорхойлох, боловсруулахад бүх оролцогч талуудаас шаардагдсан оролцоо,
- Хөтөлбөрийн чиглэл /хүмүүнлэг, байгалийн ухаан, нийгмийн ухаан, ерөний боловсрол, мэргэжлийн програмууд гэх мэт/ бүрийн хүрэхээр төлөвлөсөн үр дүнг харилцан зөвшөөрсөн байх,
- Хөтөлбөрийн хүрэхээр төлөвлөсөн үр дүнгээс боловсруулсан сайтар тодорхойлсон үр дүн бүхий хичээлүүдийн тоо эсвэл хувь,
- Үр дүнгийн зорилго, зорилтууд нь өндөр эмх цэгц бүхий чадамж, зан төлөвийг багтаасан байх.
- Хичээл бүрийн хүрэхээр төлөвлөсөн үр дүн суралцагч сайтар төлөвлөсөн, урьдчилан тодорхойлсон замаар үр дүнд хүрэхэд нь хувь нэмрээ оруулдаг байх.
- Магадлан итгэмжлэгдсэн програмуудын үр дүнгийн зорилго, зорилтууд нь хөтөлбөрийн хүрэхээр төлөвлөсөн үр дүнд тусгагдсан байдаг
- Хөтөлбөрийн дараалал нь тухайн хичээлийг үзэхийн өмнө заавал судалсан байх хичээлүүдийн сургалтын үр дүнгүүд шаардлагатай бүх чадамжийг эзэмших боломжоор хангаж өгдөг.

**B. Програмын чанарт хяналт-шинжилгээ хийх: Бодит үр дүнг мэдэх, түүнийг сайжруулах**

- Хөтөлбөрийн үр дүнгийн жагсаалт дах чадамж/мэдлэг, ур чадвар, хандлага, үнэ цэнэ/-ийг төгсөгчид эзэмшсэн эсэхийг нягтлах үнэлгээний төлөвлөгөө,
- Хөтөлбөрүүдийн олон улсын үнэлгээг хөтөлбөрийн бие даасан хичээл бүрийн хүрэхээр төлөвлөсөн үр дүнгийн үнэлгээтэй харьцуулах ,
- Сурах арга барил, үр дүн бүрт зориулсан үнэлгээний аргын ялгаатай талууд ,
- Хүрэхээр төлөвлөсөн үр дүн болон үнэлгээний техникүүдийн хоорондын ижил болон ялгаатай талууд.
- Хөтөлбөр, хичээл аль алины суралцагчийн хүрэхээр төлөвлөсөн үр дүн шууд хэмжихүйц байх.
- Хяналт-шинжилгээний үр дүн, дүгнэлтийг сонирхсон оролцогч талуудад нээлттэйгээр танилцуулах /цаг тухайд нь тэдэнд ойлгомжтой байдлаар/,
- Үнэлгээний мэдээллийг ашиглан хичээлийнхээ сурах арга барилыг сайжруулж буй багш нарын тоо,
- Тухайн хичээлээр суралцаж буй оюутны сэтгэл ханамжийн түвшин, тэдний хандлагын талаарх мэдээллийг цуглуулан түүнийг ашиглаж буй багшийн тоо.



### **С. Боловсрол олгох үйл явц: Суралцах үйл ажиллагааг бий болгох нь**

- Боловсрол олгох үйл явцын чанар /судалгаатай уялдсан/ нь оюутны сурах үйл ажиллагаанд болон хичээл, хөтөлбөрүүдийн тодорхойлсон үр дүнд хүрэхэд тусалдаг.
- Хөтөлбөрийн дизайн болон хүрэхээр төлөвлөсөн үр дүнг хэрэглэх боломжийн хоорондын холбоо (энэ нь суралцагчид өөрсдийн мэдлэг, ур чадвар, хандлага, үнэ цэнээ ашиглан нөхцөл байдал, тулгамдаж буй асуудлуудыг шийдвэрлэх боломж юм)
- Танхимаар суралцагчдын уламжлалт лекцэд зарцуулж буй цагийн хувь.
- Дадлага, кейс судалгаа, идэвхтэй заах арга, практик, судалгааны ажил гэх мэт хэлбэрээр явуулж буй идэвхтэй сурах үйл ажиллагааны хувь.
- Хөтөлбөрийн зорилго, бүтэц, зохион байгуулалт, үйл явц, сурах үүрэг хариуцлага, тэдний ахиц, хөгжлийг хэрхэн үнэлэх зэргийг оюутнууд ойлгосон байх.
- Албан ёсны академик хөтөлбөр нь хичээлийн дараах нэмэлт үйл ажиллагаа/жишээ нь: чиглүүлэх, хөгжлийн академик зөвлөгөө, манлайллын програм, үйл ажиллагаа гэх мэт/-тай холбогддог.

### **Д. Хүйсийн тэгш байдал болон бусад эрхзүйн асуудлууд**

- Суралцагчдын хүйсийн харилцааг харгалзан үзэж боловсруулсан/шинэчилсэн хөтөлбөрүүдийн тоо.
- Хөтөлбөрийн хорооны эмэгтэй гишүүдийн тоо
- Хүйсийн тэгш байдал болон холбогдох бусад асуудалтай холбоотой өмнө байсан болон одоо хэрэгжүүлж буй байгууллагын журам .
- Тэгш байдлын тухай хууль, журамтай нийцсэн сургалтын програм, хэрэглэгдэхдүүн.
- Хөтөлбөр, програм, сургалтын материалууд хүйсийн болон хүйсийн тэгш бус байдлаас ангид гэдгийг харуулсан хувь (жишээ, график, мэргэжлийн сонголт гэх мэт) хувь.
- Жэндэрийн асуудлыг тусгасан хичээл, програмуудын тоо.
- Сонгогдсон ДБСБ-уудын хүйсийн тэгш бус байдлаас ангид хөтөлбөр/програмын хувь.

### **Е. Бусад чухал асуудлууд**

- Хөтөлбөрийн хүрээнд оюутны ахиц, хүрсэн үр дүнд хяналт тавьдаг (заавал судлах болон сонгон судлах хичээлүүдэд хамрагдах боломж).
- Програмыг эдийн засгийн хувьд үр өгөөжтэй байлгахад шаардлагатай оюутны тоо .
- Тухайн програмын хүрээнд явцын дундаас завсардсан эсвэл хангалтгүй суралцсан оюутнуудын хувь хэмжэ.
- Суралцсан чиглэлээрээ салбартаа ажиллаж буй төгсөгчдийн хувь.

Тухайн ДБСБ-ын төлөөлөл өөрийн сургуулийн хөтөлбөрийн үнэлгээний чадавхийг дүгнэх хэсэг

Танай сургуульд эдгээр индикаторуудыг хэмжих мэдээлэл, дата байдаг уу? Тийм\_\_\_\_Үгүй\_\_\_\_\_

Хэрэв үгүй гэж хариулсан бол, та болон танай сургуулийн ажилтнуудыг эдгээр мэдээлэл, датаг бэлтгэхэд шаардлагатай вэ?

Та өөрийн сургуулийн хөтөлбөрүүд болон програмуудыг үнэлэхэд байх шаардлагатай гэж үзсэн нэмэлт ямар индикаторуудыг санал болгох вэ?

### **Хөтөлбөрийн хэрэгжүүлэлт**

Энэ хэсэгт бид хөтөлбөрийн хэрэгжилттэй холбогдуулан шат шатны хөтөлбөрийн хороодын хийх ажлыг тодрууллаа. Хөтөлбөрийг түвшин бүрийн хөтөлбөрийн хороогоор дамжуулан батлаж, хэрэгжүүлэх ажил 2012 оноос эхлэн МУИС болон улсын өмчийн бусад дээд сургуулиуд дээр эхлэн

хэрэгжиж байгаа бөгөөд ажлын туршлага дутах үүнээс шалтгаалах ийм чиглэлийн шинэчлэлийн ажилд таагүй хандах, үл итгэх хандлага ажиглагдаж байна. Ийм учраас хөтөлбөрийн хорооны хийх ажил, гүйцэтгэх үүргийн талаар хоёр хувилбарт санал дэвшүүлж байна. Оюутны тоо цөөн, жижиг сургуулийн хувьд эхний хувилбарыг, оюутны тоо олон хэмжээний хувьд харьцангуй том(улсын их, дээд сургуулиуд) сургуулиудын хувьд 2-р хувилбарыг сонгох нь зүйтэй гэж үзэж байна.

## **Хувилбар 1.**

### *5.2.1 Бакалаврын хөтөлбөрт өөрчлөлт оруулахаар санал хүргүүлэх процесс*

ДБСБ болон түүний бүрэлдэхүүн сургууль, тэнхим шинэ хөтөлбөр эсвэл одоогийн хөтөлбөрийг хэрэгжүүлэхдээ байгууллагын бүтэц зохион байгуулалтын хүрээнд дагаж мөрддөг үйл явцтай байх шаардлагатай. Дараагийн хэсэгт бид тэрхүү үйл явц болон суралцагчдын боловсролын туршлагыг сайжруулах хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэхэд шаардлагатай алхмуудыг танилцуулна. Мөн Монголын ДБСБ-уудын сургалтын зохион байгуулалт, онцлогт тохируулан хэрэгжүүлж болохуйц үйл явцыг боловсруулна.

Хөтөлбөр, хичээлд өөрчлөлт оруулах, эсвэл шинэ хичээл, програм нээх тухай саналыг оюутан, багш, ажилтан, удирдлага хэн ч гаргаж болно. Өөрчлөлт оруулах, академик програмуудтай холбоотой хөтөлбөрт нэмэлт оруулахдаа их сургуулийн түвшинд тухайн процес оролцох хороод, удирдлагын үүрэг хариуцлагыг тодорхойлсон журмыг удирдамж болгон ашиглана.

## **А. Шинэ хөтөлбөр**

Эхлээд тэнхим/бүрэлдэхүүн сургуулиуд шинэ хөтөлбөрт хэрхэн зөвшөөрөл авахдаа саналаа хэрхэн танилцуулах талаар авч үзье:

Шинээр хөтөлбөр санал болгохдоо холбогдох сургалтын алба, сургалт эрхэлсэн дэд захиралд байгууллагын шаардлагын дагуу дэлгэрэнгүй агуулга бүхий саналыг хүргүүлэх замаар эхэлнэ. Энэхүү агуулгын танилцуулга дараа нь тухайн програмын бүрэн саналыг боловсруулахад үндсэн баримтын үүрэг гүйцэтгэнэ.

Хэрэв санал (агуулгын танилцуулга)-ыг тэнхим/сургууль боловсруулсан бол сургууль эсвэл тэнхимээр дамжуулан их сургуулийн хөтөлбөрийн хороо/зөвлөлд хүргүүлнэ. Хөтөлбөрийн хороо тухайн агуулгатай танилцаж саналаа өгнө. Саналыг тэнхимийн эрхлэгч болон сургуулийн декан руу хүргүүлнэ.

Хэрэв саналыг декан эсвэл захирал санал болгосон бол, шууд хөтөлбөрийн хороо руу хүргүүлнэ. Уг саналд өөр салбар/бүрэлдэхүүн сургуулийн асуудал тусгагдаж байгаа бол холбогдох салбар/бүрэлдэхүүн сургуулийн декан, захиралд танилцуулахаар хүргүүлнэ. Тухайн сургуулиас саналыг дэмжсэн талаарх баримтыг хавсаргаж болно.

Сургалт эрхэлсэн дэд захирал тухайн агуулгын танилцуулгыг хянан үзсэний дараа гаргасан шийдвэрээ санал хүргүүлсэн талд мэдэгдэх бөгөөд агуулгын танилцуулгыг бүрэн програмын санал боловсруулах дараагийн шат руу шилжүүлсэн/шилжүүлээгүй талаарх ямар ч шийдвэрийг мэдэгдэх үүрэгтэй.

### **1. Хөтөлбөрийг санал болгох**

Саналыг тэнхимийн багш нар, хөтөлбөрийн хороо зөвшөөрмөгц, тэнхимийн эрхлэгч зөвлөмжүүдийг бүрэн програмын саналын хамт хөтөлбөрийн хороонд хүргүүлнэ. Хороо өөрсдийн зөвлөмжийг бүрэлдэхүүн/салбар сургуулийн захиралд болон санал ирүүлсэн тэнхим рүү шилжүүлнэ. Тэнхимийн эрхлэгч, хөтөлбөрийн хороо, багш нараас програмын талаарх санал, зөвлөмж хүлээн авсны дараа сургуулийн захирал, сургалт эрхэлсэн дэд захирал руу хүргүүлнэ. Сургуулийн захирал зөвлөмжүүдийг хүргүүлэхдээ ямар ч тохиолдолд дараах нэмэлт бичиг баримтыг хавсаргана:

- Санал болгосон хөтөлбөрийн хэрэгцээ;
- Саналыг хэрэгжүүлэхэд оролцох бусад сургуулиудын захирал, хөтөлбөрийн хороодоос саналыг дэмжсэн талаарх холбогдох материалууд;
- Санхүүгийн санал;
- Дээр дурдагдаагүй бусад шаардлагатай үйлчилгээ /номын сан, орон зайн хороо(space committee) сургалтын үйлчилгээ болон тооцоолол/-ний талаарх дүгнэлтүүд;
- Их сургуулиас тавьдаг шаардлагуудтай холбоотой бусад мэдээллүүд.

#### В. Хичээлд томоохон өөрчлөлт оруулах, шинэ хичээл, тусгай хөтөлбөрүүд

Дээр дурдсан томоохон өөрчлөлт оруулах, шинээр нээх, тусгай хөтөлбөрүүдийн талаарх саналуудыг тэнхимийн хөтөлбөрийн хороо, тэнхимийн багш, тэнхимийн эрхлэгчид хүргүүлнэ.

Одоо хэрэгжүүлж буй хичээлд оруулах томоохон өөрчлөлтүүд гэдэгт дор дурдсан шинжүүдээс аль нэгийг нь агуулж байгаа өөрчлөлтүүд багтана. Үүнд:

- Санал болгож буй өөрчлөлт нь бусад тэнхим эсвэл бүрэлдэхүүн/салбар сургуульд нөлөөлөхүйц;
- Санал болгож буй өөрчлөлт нь багц цаг, contact hours, урьдчилсан нөхцөл, хасалт зэрэг статустай хамааралтай бол;
- Санал болгож буй өөрчлөлт нь оюутанд илэрхий нөлөө үзүүлэхүйц хичээлийн бүхий л хэсгийн заах арга барилд оруулах өөрчлөлт багтсан бол.

Дээр дурдсан (В) саналуудын хувьд, тэнхимийн эрхлэгч баталсан саналуудаа хөтөлбөрийн хороонд хүргүүлнэ. Хөтөлбөрийн хороо ирүүлсэн саналтай танилцаж хэлэлцсэний дараа санал, зөвлөмжийн хамт захиралд танилцуулна.

Хэрэв санал нь бусад сургууль/тэнхим эсвэл оюутанд нөлөөлөхөөр бол захирал холбогдох сургуулийн захиралд мөн хүргүүлнэ. Тэднээс ирүүлсэн санал, зөвлөмжийн хамт хөтөлбөрийн саналаа шийдвэрлүүлэх, батлуулах арга хэмжээ авахуулахаар сургалт эрхэлсэн дэд захиралд хүргүүлнэ. Хичээлийг санал болгож буй сургуулийн захирлаас ирүүлсэн зөвлөмжийг тухайн хичээлийн саналын эрэлт хэрэгцээ, төсвийн шаардлагууд бүхий баримтуудын хамт хавсаргана. Хичээлд оруулах өөрчлөлтийг баталмагц, санал оруулсан сургуулийн захирал холбогдох мэдээллийг оновчтой, зөв түгээсэн эсэхэд хяналт тавина.

#### С. Хичээлд жижиг засвар оруулах

Хичээлд засвар оруулахтай холбоотой аливаа саналыг тэнхимийн хөтөлбөрийн хороо, тэнхимийн багш, тэнхимийн эрхлэгчид хүргүүлнэ. Тэнхимийн эрхлэгч тэдгээр өөрчлөлтийг оруулах эсэх талаар зөвшөөрөл өгөх эрх бүхий хүн байна. Саналтай холбоотой хэрэгжүүлсэн аливаа үйл ажиллагааны талаар сургуулийн захиралд мэдэгдсэн байна.

#### 5.2.2 Их сургуулийн хөтөлбөрийн хорооны бүрэлдэхүүн

Хөтөлбөрийн хороо нь дараах бүрэлдэхүүнтэй байна. Үүнд:

- Сургалт эрхэлсэн тэргүүн дэд захирал хорооны дарга байна.;
- Сургалтын албаны дарга нарын төлөөлөл;
- Сургалтын сенат/эрдмийн зөвлөлөөс сонгогдсон төлөөлөл;
- Оюутны холбооны төлөөлөл;
- Багш нарын төлөөлөл;

Сонгогдсон төлөөлөл бүр хөтөлбөрийн хорооны санал өгөх эрхтэй гишүүн байна. Хугацааны хувьд, төгсөгчдийн төлөөллөөс бусад нь 3 жилийн хугацаатай сонгогдоно. Ингэхдээ ойролцоогоор гишүүдийн 1/3 нь жил бүр шинэчлэгдэж байхаар хугацааг тооцон сонгоно. Оюутны холбооны

төлөөллийн хувьд оюутнууд 4 жилийн хөтөлбөрийн 3 дах жилээс оролцох боломжтойгоос хамааран сонгогдох хугацаа нь бусад гишүүдээс өөр байна.

Хөтөлбөрийн хорооны чиг үүрэг, үйл ажиллагаа нь:

- Бүрэлдэхүүн/салбар сургуулиудаас ирүүлсэн хөтөлбөрүүдийн саналыг их сургуулийн хэмжээнд /university-wide perspective/ судлан үзэх;
- Хөтөлбөртэй холбоотой асуудлаар их сургуулийн хэмжээнд харилцааны оновчтой хэлбэрийг бий болгох;
- Одоо хэрэгжүүлж буй хөтөлбөрүүдэд тогтмол хяналт-шинжилгээ хийж, шинэчилж байгаа эсэхийг бататгах;
- Их сургуулийн хэрэгжүүлж буй ерөнхий боловсролын хөтөлбөрт хяналт-шинжилгээ, анализ, үнэлгээ хийх хороо байгуулагдсан эсэхэд хяналт тавих;
- Санал болгож буй програм их сургуулийн хэтийн төлөвлөгөөтэй уялдаж байгаа эсэхийг судлах;
- Их сургуулийн хэрэгжүүлж буй бичлэг/writing/-ийн хөтөлбөрт хяналт тавих, дэмжлэг үзүүлэх, дүн шинжилгээ, үнэлгээ хийх хороо байгуулагдсан эсэхэд хяналт тавих;
- Дараагийн хичээлийн жилд хянагдах хөтөлбөрийн санал хүргүүлэх журмыг их сургуулийн бүх сургалтын нэгжид нээлттэй байлгах.

### 5.2.3 Төгсөгчдийн зөвлөл

Төгсөгчдийн зөвлөл нь Эрдмийн зөвлөлийн байнгын дэд хороо байх ба дараах бүрэлдэхүүнтэй байна. Үүнд:

- Их сургуулийн салбар сургууль бүрээс төгсөлтийн дараах боловсролын талаар туршлагатай нэг багш байна;
- Төгсөлтийн дараах хөтөлбөрийн эрхлэгч;
- Төгсөгчдөөс зохих ёсоор сонгогдсон төлөөлөл;
- Сургалт эрхэлсэн дэд захирал эсвэл проректор.

Коллеж бүрийн төлөөлөл хөтөлбөрийн хороо буюу хороодын санал өгөх эрхтэй гишүүн байна. Хугацааны хувьд, төгсөгчдийн төлөөллөөс бусад нь 3 жилийн хугацаатай сонгогдоно. Ингэхдээ ойролцоогоор гишүүдийн 3/1 нь жил бүр шинэчлэгдэж байхаар хугацааг тооцон сонгоно. Төгсөгчдийн төлөөлөл 1 жилийн хугацаатай сонгогдоно. Багш нарын төлөөлөл дахин сонгогдож болно.

Төгсөгчдийн зөвлөлийн чиг үүрэг, үйл ажиллагаа

Төгсөгчдийн зөвлөл нь төгсөлтийн дараах боловсролд хяналт тавьж, өндөр чанартай төгсөлтийн дараах боловсролын хөтөлбөрүүдийг хөгжүүлэх, боловсронгуй болгоход дэмжлэг үзүүлнэ. Төгсөлтийн дараах боловсролтой холбоотой бодлого боловсруулах, санал болгох, бодлогын саналуудыг үнэлэх, тэдгээр бодлого, журмын хэрэгжилтэд хяналт-шинжилгээ хийх үүрэгтэй.

Эдгээр үйл ажиллагааг гүйцэтгэхийн тулд Зөвлөл:

- Төгсөлтийн дараах хөтөлбөрүүдийн саналыг их сургуулийн хэмжээнд авч үзэн судлах, их сургуулийн түвшинд хөтөлбөртэй холбоотой оновчтой харилцаа холбоог хангаж өгөх;
- Төгсөлтийн дараах хөтөлбөрийг зогсоох, эсвэл батлуулахтай холбоотой саналыг Эрдмийн зөвлөл /Academic Senate/-д санал болгох;
- Одоо хэрэгжүүлж буй хөтөлбөрүүдэд тогтмол хяналт-шинжилгээ хийх;
- Төгсөлтийн дараах боловсролтой холбоотой бодлогын нэмэлт, өөрчлөлтүүдийг Эрдмийн зөвлөлд санал болгох.

Эдгээр зарчмуудыг өөр бүтэц, зохион байгуулалт, нэрийн дор ДБСБ-ууд авч хэрэгжүүлэх бүрэн боломжтой. Гол санал болгох зүйл нь ДБСБ-ууд өөрийн нөхцөлд тохируулан хэрэгжүүлэхдээ үүрэг, хариуцлагыг нь тодорхойлсон энгийн, тохирсон, тодорхой үйл явц байх шаардлагатай. ДБСБ-ын хөтөлбөрийн бүтэц, механизмын гол үндэслэл нь оюутнуудын боловсрол эзэмших бүхий л явцад чанартай, нийцтэй, орчин үеийн боловсрол олгох гэдгийг цаг ямагт санаж байх нь чухал.

Монгол улсын зарим их, дээд сургуулиуд дээр хөтөлбөрийн ерөнхий хороо хөтөлбөртэй холбоотой асуудлаар бүх шийдвэр гаргадаг практик ажиглагдаж байгаа нь хэт төвлөрч, асуудлыг уян хатан, хурдтай шийдэх боломж олгохгүй байгаа байдал ажиглагдаж байна. Иймд хөтөлбөртэй холбоотой асуудлуудаар их, дээд сургуулиуд дахь нэгж, бүтцүүдийн гаргах шийдвэрүүдийг хуваарилсан өөр нэг хувилбарыг санал болгож байна.

Мөн хөтөлбөртэй холбоотой шийдвэр гарах процесс нь дээрээс доош чиглэсэн урсгалаар биш багш болон сургуулийн үндсэн нэгжээс эхлэн тодорхой шат дамжлагуудыг дамжин шийдвэр гаргах дээд түвшний нэгжид хүрэх чиглэлд өрнөх процесс гэж үзэн дараах диаграмыг санал болгож байна.

## **Хувилбар 2. Хөтөлбөртэй холбоотой бүтэц, нэгжүүдийн гаргах шийдвэрийн хуваарилалт**

### **Эрдмийн зөвлөл/Удирдах зөвлөлийн шийдэх асуудал**

- Зэрэг олгох шинэ хөтөлбөр нээх, хөтөлбөрийн загвар шинээр батлах
- Одоо байгаа хөтөлбөрийг ердийнхөөс тусгай тэтгэлэгт хөтөлбөр болгон өөрчлөх
- Өдрийн болон гүнзгий чиглэлээр мэргэшлийн шинэ салбар нээх, загварыг батлах
- Хөтөлбөрийн нэр өөрчлөх
- Хөтөлбөрт элсэх шаарлагыг өөрчлөх
- Элсэлтийн хяналтын тоог өөрчлөх
- Шинэ нөөц, хөрөнгө шаардагдах, хөтөлбөр дэхь өөрчлөлт (ж нь : 4 жилийн сургалтаас 5 жилийн сургалтанд шилжих, тезис суурилсан хэлбэрээс курсэд суурилсан хэлбэрт шилжих)
- Хөтөлбөрийг хаахтай холбоотой асуудлууд
- Хөтөлбөр, мэргэшлийг хаах
- Мэргэшлийн чиглэлийг хаах

### **Хөтөлбөрийн хорооны шийдэх асуудал**

- Гүнзгийрүүлсэн хөтөлбөр нээх
- Сургууль хоорондын хавсрага хөтөлбөр
- Хөтөлбөр дэхь өөрчлөлт (ж нь. Зарим хичээл нэмэх, хасах).
- Мэргэшлийн нэр өөрчлөх.
- Хөтөлбөрийн шаардах кредит цагийг өөрчлөх.
- Шинэ хичээл нэмэх
- Адилтгаж, дүйцүүлэх хичээл, бусад сургуультай харилцан зөвшөөрөх хичээл
- Урьдчилсан шаардлагын өөрчлөлт
- Хичээл хаах

-Хөтөлбөрийн өөрчлөлт: Батлагдсан хөтөлбөр дэхь хичээлийг орлуулах, дүйцүүлэх; Батлагдсан хөтөлбөр дэхь том хэмжээний өөрчлөлт (бүтэц, агуулга, хуваарилалт). Батлагдсан хөтөлбөрийн шаардлагыг нэмж/хасах

Хавсрага хөтөлбөр дэхь өөрчлөлт


-Батлагдсан хөтөлбөр дэхь хичээлийн өөрчлөлт нь харьяа нэгжээс гаднах хичээл, хөтөлбөрт нөлөө үзүүлэхүйц байх тохиолдолд

### **Бүрэлдэхүүн сургуулийн шийдэх асуудал**

Дараах өөрчлөлтүүдийг шийдвэрлэнэ:

- “Хос” гүнзгий, эсвэл “Хос” мэргэжлийн хөтөлбөрийн өөрчлөлт
- Анги дэвших болон төгсөлттэй холбоотой шаардлагыг өөрчлөх.

- Хичээл дэх өөрчлөлт: Нэршил, тоонууд, түвшин, Calendar description, кредит цагийн нэгж, агуулга, лекцийн цаг, үнэлгээ
- Элсэлтийн квот дахь гадаад оюутны тоог өөрчлөх
- Тухайн хичээлийн лекц, семинар, дадлага, лаборатори, хэлэлцүүлэг гэх мэт хэлбэрүүдийн харьцаа
- Батлагдсан хичээлийн агуулгын зарим хэсгийг өөрчлөх, хасах
- Үнэлгээний арга, хэлбэрийн өөрчлөлт
- Хөтөлбөр дэхь сонгон судлах хичээлүүдийн өөрчлөлт
- Магистр, Докторын хөтөлбөрийн шаардлагын зарим өөрчлөлт



Зураг 1 Хөтөлбөр батлах болон хөтөлбөртэй холбоотой бусад асуудлыг шийдвэрлэх үйл явц

## 6 Дүгнэлт

Энэхүү модулийн гол зорилго нь сонгогдсон ДБСБ-уудын сургалт хариуцсан удирдлагууд өөрийн байгууллагын одоогийн процесс, бүтэц, зохион байгуулалт, процедурыг хянан үзэж, эдгээрээс өөрсдийн нөхцөлд тохируулан хэрэгжүүлэх боломжийг олгоход оршино. Эцэст нь эдгээр зарчим, саналуудыг Монгол улсын бүх ДБСБ-уудад хүргүүлснээр тэдгээр сургуулиуд өөрсдийн бүтэц, зохион байгуулалтуудаа нэгтгэж, өөр өөрийн онцлогт тохируулан хэрэгжүүлэх боломжтой болно.

Эцэст нь бид хөтөлбөр нь Монгол улсын ДБСБ-уудад суралцаж буй өнөөгийн болон маргаашийн оюутнуудын амжилт, хүрэх үр дүнгийн гол цөм юм гэдгийг дахин давтан хэлэхийг хүсч байна. Тиймээс ДБСБ энэхүү чухал үйл ажиллагаанд онцгой анхаарч, шаардлагатай нөөц бололцоогоор хангаж өгөх нь чухал юм.

Хөтөлбөрийн хувьсал, өөрчлөлт нь ДБСБ-уудад дээд боловсролын үүрэг хариуцлагатай холбоотой нийгмийн шаардлага, хэрэгцээг тусган хэрэгжүүлэхэд тусалдаг байна. ДБСБ-ууд нь ажил олгогчдын шаардлагад нийцүүлэн сайтар бэлтгэгдсэн ажиллах хүч бэлтгэн гаргах ажил олгогчдын шаардлагад нийцүүлэх явцдаа оюутныг маргаашийн мэдлэгт суурилсан нийгэмд бэлтгэх, тэднийг “насан туршийн суралцагч” болгон бэлтгэх шаардлага тулгарч буй энэ үед юуг сургасан нь их сургуулийн амжилтад чухал байсаар байх болно. Багш төвтэй арга барилаас асуудал шийдвэрлэх үйл ажиллагаа, “бодит амьдрал”-ын нөхцөл байдал бүхий оюутан төвт арга барил руу шилжих нь суралцахуйн тогтвортой үйл ажиллагаанд ихээхэн хувь нэмрээ оруулна. Хөтөлбөр өөрөө төгсгөл биш учир түүний ач холбогдлыг бууруулах боломжгүй юм. Нийгэм болон түүний олон бүрэлдэхүүн хэсгүүдийн хүлээлтэд нийцүүлэхийн тулд ДБСБ-ууд өөрийн хариуцлага хүлээх чадвар, нийцтэй байдлаа нэмэгдүүлэх шаардлагатай.

Хөтөлбөрийг нийгмийн, дотоод, гадаад нөхцлийг тусгасан сургалтын төлөвлөгөө гэж тодорхойлсоор ирсэн. Энэ модульд санал болгосон хөтөлбөрийн загвар, туршилтын төсөл нь хичээл, програм, их сургуулийн түвшний хөтөлбөрүүдийн асуудлуудыг анхаарч үзэхэд зориулсан системтэй хүрээ/framework/-г бий болгож, багш, удирдлагууд сургалтын төлөвлөгөөг үр дүнтэй боловсруулах, хяналт шинжилгээ хийх, үнэлэхэд дэмжлэг үзүүлнэ. Санал болгож буй загвар нь сургалтын төлөвлөгөөг төлөвлөгөөний элементүүдэд нөлөөлөх дотоод, гадаад хүчин зүйлд чиглэсэн боловсролын тусгай орчинд боловсруулагддаг гэдгийг бататгаж байна. Хөтөлбөр боловсруулах нь цуврал шийдвэрүүдийг гаргах замаар сурах төлөвлөгөө зохиох цогц үйл явц юм. Энэ нь сургах, сурахуйн талаар шинэлэг үйл явцыг бий болгохоор багш, удирдлагууд санал солилцох, асуудлыг шийдвэрлэх замаар оролцдог өөрчлөлт, шинэчлэлийн тасралтгүй үйл явцыг бий болгодог. Ингэснээр багш, удирдлагууд өөрийн ДБСБ-уудын бүх түвшний сургалтын амжилтаа ахиулах боломжуудаа нэмэгдүүлэх арга, процессоо сонгох боломжтой болно.

Өмнө дурьдсанчлан хөтөлбөр нь Төлөвлөсөн, Хэрэгжсэн, Оюутанд хүрсэн гэдэг 3 хэлбэрт байдаг бөгөөд эдгээр гурван хэлбэрийн шат болгонд онцгой анхаарах шаардлагатай. Одоогийн байдлаар их дээд сургуулиуд зөвхөн хөтөлбөрийн төлөвлөлтөнд анхаарч цаасан дээр хөтөлбөрөө боловсруулан хөтөлбөрийг хэрэгжүүлэх(сургалтын өдөр тутмын хяналт, багшийн заах арга зүй), төлөвлөж, хэрэгжүүлж буй хөтөлбөрийг оюутан хэрхэн эзэмшсэнийг үнэлэх үнэлгээ хоёрыг орхигдуулах хандлагатай байгааг анхаарах шаардлагатай.

Хөтөлбөрийг түвшин бүрийн хөтөлбөрийн хороогоор дамжуулан батлаж, хэрэгжүүлэх арга барил 2012 оноос эхлэн МУИС болон улсын өмчийн бусад дээд сургуулиуд дээр эхлэн хэрэгжиж байгаа бөгөөд ажлын туршлага тутах байдал ажиглагдаж байна. Ийм учраас 5-р хэсэгт хөтөлбөрийн хорооны хийх ажил, гүйцэтгэх үүргийн талаар хоёр хувилбарт санал дэвшүүлсэн. Оюутны тоо цөөн, жижиг сургуулийн хувьд эхний хувилбарыг, оюутны тоо олон хэмжээний хувьд харьцангуй том(улсын их, дээд сургуулиуд) сургуулиудын хувьд 2-р хувилбарыг сонгох нь зүйтэй гэж үзэж байна.

## АШИГЛАСАН МАТЕРИАЛ

1. Barnett, R. & Coates, K. (2005) A Schema. In Engaging the curriculum in Higher Education (p. 67-69). Berkshire: SRHE & Open University Press.
2. Biggs J. (2003) Teaching for Quality Learning at University. 2nd ed. Buckingham: The Society for Research into Higher Education & Open University Press; pp. 34–55.
3. Gardner, L. (2000) Faculty Development in Higher Education. National Academy for Academic Leadership.
4. Jacobs, H. editor, (2004). Getting Results with Curriculum Mapping. Alexandria, VA: ASCD
5. Joyce, B., Weil, M., Calhoun, E. : Models of teaching, 6th edition, Allyn & Bacon, 2000
6. Kuh, G.D. (2008) High-Impact Educational Practices: What They Are, Who Has Access to Them, and Why They Matter Association of American Colleges and Universities

7. Lattuca, L.R. (2006) Curricula in International Perspective. In J.J.F Forest & P.G. Altbach (Eds.), *International Handbook of Higher Education, part one: Global Themes and Contemporary Challenges* (pp. 39-64). The Netherlands: Klumer/Springer.
8. Lattuca, L.R. & Stark, J.S. (2009) *Shaping the College Curriculum: Academic Plans in Context*. San Francisco: Wily & Sons.
9. Porter, A.C. (2005) Curriculum assessment. In J. L. Green, G. Camilli, & P. B. Elmore (Eds.), *Complementary methods for research in education* (3rd edition). Washington, DC: American Educational Research Association.
10. Wolf, P. (2007) A model for facilitating Curriculum Development in Higher Education: A Faculty Driven, Data-Informed and Educational developer-Supported Approach, in *Directions for Teaching and Learning* pp. 15-20.
11. Various websites were also consulted on Curriculum Development, Design and Evaluation in all regions of the globe.